

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-30

-
- 1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 5-15*
- 2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/ 15*
- 3. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/ 15-16*
- 4. “Биеийн тамир, спортын салбарын 2022-2023 оны үйл ажиллагаа” сэдвээр Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын мэдээлэл сонсох 16-30*

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
06 дугаар сарын 13-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл***

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 68.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 22 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Чөлөөтэй: П.Анужин, Ё.Баатарбилэг, Х.Ганхуяг;
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг.*

Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Соёлын сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Б.Жавзанжаргал, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, мөн газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ш.Алтангэрэл, Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг

зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Н.Амарбаяр, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Энх-Амгалан, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга С.Батцэцэг, Хөрөнгө, оруулалтын хэлтсийн дарга Т.Бямбасүрэн, Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга О.Гэрэл, мөн хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэрэнболд, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Д.Рэгдэл, мөн академийн Тэргүүлэгчдийн газрын дарга А.Баярбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Төсвийн төслийн талаар Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Ч.Ундрам нарын тавьсан асуултад Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Энх-Амгалан, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Мөнхцэцэг: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Х.1.1.65.Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2019-2023, төсөвт өртөг 7,593.9 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 1,086.3 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн төсөвт өртөг “7,593.9 сая төгрөг” гэснийг “10,246.0 сая төгрөг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 1 |
| Татгалзсан: | 10 |
| Бүгд: | 11 |

9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёлын сайд Ч.Номин, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Энх-Амгалан, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга С.Батцэцэг, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Бямбасүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Мөнхцэцэг: “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы тавьсан асуултад Байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг хариулж, тайлбар хийв.

Г.Мөнхцэцэг: “Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11

81.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Биеийн тамир, спортын салбарын 2022-2023 оны үйл ажиллагаа” сэдвээр Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Олимп, биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны дарга Э.Тэмүүжин, Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга О.Гэрэл, мөн хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэрэнболд, Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Э.Билэгт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

“Биеийн тамир, спортын салбарын 2022-2023 оны үйл ажиллагаа” сэдвээр Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Г.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга О.Гэрэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Биеийн тамир, спортын салбарын 2022-2023 оны үйл ажиллагаа”-ны талаарх Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнийн мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 16 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 38 минут үргэлжилж, ирвэл зохих 16 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.МӨНХЦЭЦЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр,
Мягмар гараг

Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим 14 цаг 22 минут.

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Мөнхцэцэг: Эрхэм гишүүдийн
энэ өдрийн амгаланг айлтгая.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын байнгын хорооны 2023 оны 6
дугаар сарын 13-ны өдрийн хуралдаан
эхлэх гэж байна.

Хуралдаанд ирсэн гишүүдийг
дэгийн дагуу танилцуулъя. Амгалангийн
Адъяасүрэн Баянхонгор аймаг 3 дугаар
тойрог, Пүрэв-Очирын Анужин
Сонгинохайрхан дүүрэг 28 дугаар тойрог
одоогоор арай амжаагүй байх шиг байна.
Тилеуханы Аубакир Баян-Өлгий аймаг 2
дугаар тойрог ирсэн байна.
Ёндонпэрэнлэйн Баатарбилэг Архангай
аймаг 1 дүгээр тойрог чөлөөтэй байна.
Балжиннямын Баярсайхан Завхан аймаг
9 дүгээр тойрог ирсэн байна. Энхбаярын
Батшугар Сонгинохайрхан дүүрэг 28
дугаар тойрог ирсэн байна. Хассуурийн
Ганхуяг Баянгол дүүрэг 26 дугаар тойрог
өнөөдөртөө ирээгүй байна. Гонгорын
Дамдинням Дархан-Уул аймаг 19 дүгээр
тойрог ирсэн байна. Бадарчийн
Жаргалмаа Сүхбаатар дүүрэг 27 дугаар
тойрог ирсэн байна. Цэрэнжамцын
Мөнхцэцэг Сүхбаатар дүүрэг 24 дүгээр
тойрог өвчтэй байна. Чинбатын Ундрам

Д.ОТГОНДЭЛГЭР

Сэлэнгэ аймаг 13 дугаар тойрог ирсэн
байна. Ням-Очирын Учрал
Сонгинохайрхан дүүрэг 28 дугаар тойрог
одоохондоо ирээгүй байна.
Жигжидсүрэнгийн Чинбүрэн Баянзүрх
дүүрэг 23 дугаар тойрог ирсэн байна.
Содномын Чинзориг Өвөрхангай аймаг 10
дугаар тойрог ирсэн байна.
Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Хөвсгөл
аймаг 17 дугаар тойрог ирсэн байна.

Ирц 68.8 хувьтай байгаа учраас
өнөөдрийн хуралдааныг эхэлье.
Хуралдаанд хэлэлцэх асуудлыг
танилцуулъя.

Нэгт, Монгол Улсын 2023 оны
төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах
тухай хууль, Нийгмийн даатгалын
сангийн 2023 оны төсвийн тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл
мэндийн даатгалын сангийн 2023 оны
төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах
тухай хуулийн төсөл, Засгийн газраас
2023 оны 6 дугаар сарын 8-ны өдөр өргөн
мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлгийг явуулна.
Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын
хороонд хүргүүлэхээр байгаа.

Хоёрдугаарт нь ажлын хэсэг
байгуулах тухай байгаа. Байнгын
хорооны тогтоолын төслийг батална.
Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих
тухай хуулийн төсөл болон хамт өргөн
мэдүүлсэн хуулийн төслүүд дээр ажлын
хэсэг гаргах байгаа.

Гуравдугаарт, Байнгын хорооны
тогтоолын төсөл байгаа. 6 дугаар сард
хэлэлцүүлэх асуудлаар цаглавар
батлахаар байгаа.

Дөрөвдүгээрт нь Биеийн тамир,
спортын салбарын 2022-23 оны үйл
ажиллагааны сэдвээр Монгол Улсын
сайд, Олимп, нийтийн биеийн тамир,

спортын үндэсний хорооны даргын мэдээллийг сонсохоор байгаа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүн байна уу? Алга байна. хэлэлцэх асуудалдаа оръё.

Төсвийн тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэнэ.

Асуудал хэлэлцэхийн өмнө хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулна. Сангийн сайд Жавхлан, Сангийн дэд сайд Мөнгөнчимэг, Монгол Улсын Ерөнхий аудитор Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг, Сайннjamбуу Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор, Энхболд Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Чимэдсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Одонтуяа Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Төгөлдөр Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Цолмон Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Очиртогтох

Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Алтантуяа Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Цолмон Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Булгантуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд, Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Алимаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Баярмаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүл, бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Батжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт зохицуулах газрын дарга, Тунгалагтамир Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

Боловсролын яамнаас Энх-Амгалан Боловсрол, шинжлэх ухааны сайд, Ганбаяр Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд, Хуягцогт Боловсрол, соёл, шинжлэх ухаан яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Жавзанжаргал Боловсрол, шинжлэх ухааны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга. Ням-Очир Боловсролын Ерөнхий газрын дарга, Алтангэрэл Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Амарбаяр Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Соёлын яамнаас Соёлын сайд Номин, Энх-Амгалан Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Отгонбат Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батцэцэг Соёлын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Бямбасүрэн Соёлын яамны хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Баянзул Соёлын яамны Стратеги хөгжлийн бодлогын төлөвлөлтийн газрын дарга.

Биеийн тамир, спортын үндэсний хорооноос Бат-Эрдэнэ Монгол Улсын сайд, Олимп, биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, О.Гэрэл Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Цэрэнболд Биеийн тамир спортын улсын хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга.

Шинжлэх ухааны академиас бүрэлдэхүүн байна уу? Шинжлэх ухааны академи. Рэгдэл Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч, Баярбаатар Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газрын дарга ийм бүрэлдэхүүнтэй өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Ингээд Монгол Улсын 2023 онд төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн Сангийн сайд Жавхлан танилцуулна. Жавхлан сайдыг микрофонд урьж байна.

Б.Жавхлан: Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас экспортыг эрчимжүүлж гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7.9 хувиар өсөж, гадаад валютын нөөц энэ оны эхний 5 сарын байдлаар 3.8 тэрбум долларт хүрч сайжраад байна.

Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр инфляцад төдийлөн буурахгүй иргэдийн бодит орлогод нөлөөлж байгаа тул ард иргэдийн орлого, амьжиргааг дэмжих зайлиггүй шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан

Монгол Улсын Засгийн газраас иргэдийнхээ орлогын баталгаа, амьдрах орчныг сайжруулах, хотын түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгалаа. Тухайлбал,

1.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрд олгохын зэрэгцээ хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд нөхөж олгох.

2.Тэтгэврийг энэ зөрүүний асуудлыг цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар шийдвэрлэх, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчилж, суурь цалингийн хэмжээг нэмэгдүүлэх.

4.Нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж авто замын сүлжээг өргөтгөх зэргээр нийслэлийн түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг төсөв хооронд зохицуулалт хийж шийдвэрлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгаад байна.

Төсвийн тодотголын арга хэмжээний үр дүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1.7 их наяд төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлага 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдэх бөгөөд нэгдсэн төсвийн нийт алдагдал 1.6 их наяд төгрөг буюу анх батлагдсан дотоодын нийт бүтээгдэхүүний 2.6 хувиас хэтрүүлэхгүй байхаар төлөвлөлөө.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Мөнхцэцэг: *Жавхлан сайд баярлалаа. Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орон гүйцэтгэгч Наранчимэг тавина. 3 дугаар микрофон дээр. 3 дугаар микрофоныг өгье. Наранчимэг дарга хэддүгээр микрофон юм, 3 биз дээ? 3 дугаар микрофон.*

Ц.Наранчимэг: *Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,*

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллага дараах дүгнэлтийг гаргалаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 20 их их наяд 781.9 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34.5 хувь, нийт зарлагын хэмжээг 22 их наяд 371.4 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37.2 хувь, төсвийн алдагдлыг 1 их наяд 589.5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2.6 хувь байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Боловсрол шинжлэх ухааны сайдын төсөв батлагдсан төсвөөс 416.6 тэрбум төгрөгөөр, Соёлын сайд 46.1

тэрбум төгрөгөөр, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын төсөв 24.7 тэрбум төгрөгөөр тус тус өөрчлөлт оржээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлын төсөв нь 489.4 тэрбум төгрөгөөр өсөхөд төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон, ажил олгогчдоо төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдэж байгаа нь голлон нөлөөлсөн байна.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан шаардлагыг бүрэн хангасан гэж дүгнэлээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Мөнхцэцэг: *Наранчимэг даргад баярлалаа. Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсөв хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлсэн. Та бүхэнд бас тараасан байгаа.*

Ингээд хууль санаачлагчдаас болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух асуулттай гишүүд байна уу? Нэрсээ өгье. Байхгүй юм уу? Энэ техникийн саатал гараад байх шиг байна. Гишүүд, энэ яагаад болохгүй байгаа юм. Манай техникийнхэн бас анзаарч харж байгаа байх. Энэ гишүүд нэрээ өгөх гэсэн орохгүй байгаад байна. Баярсайхан гишүүн, Ундрэм гишүүн өшөө өөр асуулт асуулттай гишүүд байгаа юм уу? Баярсайхан, Ундрэм гишүүдээр тасаллаа.

Баярсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Баярсайхан: Баярлалаа. Төсвийн тодотголыг дэмжиж байгаа. Ялангуяа энэ хүүхдийн мөнгийг 9 хувьд нөхөн олгож байгаа, хүүхдэд ялгаварлахгүйгээр Монгол Улсын бүх хүүхдэд хүүхдийн мөнгө очиж байгаад бол бас талархаж байгаа. Тэгээд Жавхлан сайдаас 1 асуулт байна. Энэ соёлын салбарынхны цалин нэмэгдэхдээ тэр соёлын театрт ажилладаг албан хаагчдын 5 жил тутам тэтгэмж авах тэр асуудал ерөөсөө орохгүй байгаа юу тээ. Тэр нэмэгдэх боломжтой юу? Улсын хэмжээнд нийт яг хэдэн хүн энэ соёлын салбарт ажилладаг юм бол? Яг улсын хэмжээнд хэдэн хүний цалин нэмэх шаардлагатай болдог юм бол? Ер нь яваандаа энэ асуудлыг анхаарахгүй бол театрт байгаа хэдхэн тооны хүн чинь 1 хүн дээр хэчнээн тоон ажил, албан тушаалд ингэж хөрвөж ажилладаг юм? Зарим нь бүүр жүжигчин болчихсон явж байдаг шүү дээ. Жүжиглэдэг, юмаа зөөнө, жижүүрээ хийнэ гээд театрт ажиллаж байгаа хүмүүсийн тэр цалингийн асуудал ер нь аль хэсэг нь шийдэгдээд, аль нь нэмэгдэхгүй байгаа тал дээр тодорхой мэдээлэл өгөөд өгөөч.

Г.Мөнхцэцэг: Соёлын соёлын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас асууя.

Баярсайхан гишүүний асуултад. Цалин тэтгэмжтэй холбоотой асуулт асууж байгаа учраас энэ Нийгмийн хамгааллын яам Булгантуяа сайд байна уу? Соёлын яамнаас Төрийн нарийн бичиг Энх-Амгалан Баярсайхан гишүүний асуултад хариулъя. 7 дугаар микрофон дээр очоод суучих.

Ч.Энх-Амгалан: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Сая соёлын албан хаагчдын орон нутагт ажиллаж байгаа 5 жилийн нэмэгдлийг сайдын багцаасаа манайх шийдвэрлээд орон нутагт үндсэндээ 2200 гаруй албан

хаагчдын 5 жилийн нэмэгдлийг сая бүрэн олголт хийгдээд явж байна. Соёлын салбарт төсөвт байгууллагын хүрээнд нийтдээ 6235 албан хаагчид өнөөдрийн байдлаар ингээд ажиллаж байна.

Г.Мөнхцэцэг: Асуултад дутуу л хариулчих шиг болох юм. Тийм. Цалинтай холбоотой асуулт асуусан учраас тийм Нийгмийн хамгааллын яамнаас нэмээд хариулчих даа. Тийм сайд ирээгүй байгаа биз дээ. Тэгвэл Соёлын яамнаас цалинтай холбоотойгоор асуулт асуусан шүү дээ. Асуултаа гүйцэд сонсоогүй юм уу? Отгонбат дарга хариулъя цалинтай. Соёлын яамны Отгонбат дарга 7 дугаар микрофон дээр хариулт өгөөрэй.

Ж.Отгонбат: Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбат Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Сая Баярсайхан гишүүн бол 2 юуг асуучих шиг боллоо.

Нэгдүгээрт төрийн үйлчилгээний албан хаагч Соёлын тухай хуулиараа 5 жилийн ажилласан бол 6 сарын нэмэгдэл авах ёстой. Энийгээ төрийн үйлчилгээний нийтлэг албан хаагчдад олгогдоогүй энийг төсөв дээр сууж байгаа юу, энэ яаж олгогдох вэ гэж асууж байх шиг байна. Энэ дээр бол нийт 2300 орчим төрийн соёлын СТҮ буюу мэргэжлийн чиг үүргийн албан хаагчдад энэ 5 жилийн нэмэгдлийг олгосон. ТҮ буюу харуул, үйлчлэгч, манаач, нятлан гэх мэт нийтлэг үйлчилгээний албан хаагчдад энэ 5 жил ажилласан тутам 6 сар олгох нэмэгдэл олгогдоогүй.

Театрын албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгодог уу гэж асуусан. Энэ бол Засгийн газрын 382 дугаар тогтоолоор хөдөө орон нутагт аж ажиллагдаж байгаа соёлын салбарын албан хаагчдад ийм ялгавартай олгогдоод байгаа. Энэ нь бол тухайн мэргэжлүүд заачихсан байдаг Засгийн газрын тогтоол дотор.

Тэгэхлээр өөрөөр хэлбэл энд сумын соёлын төвийнхөн авч байна, музей, номын сан дотроо мэргэжлээсээ хамаараад ялгавартай олгогдоод байж байгаа. Орон нутгийн театрт ажиллаж байгаа албан хаагчид энэ орон нутгийн нэмэгдлийг огт авдаггүй. Энэ нь өөрөө Засгийн газрын тогтоолдоо суугаагүй учраас энэ маань цаашидаа Засгийн газрын тогтоол дээрээ нэмэлт, өөрчлөлт ороод ингээд шийдвэрлэгдээд явах байх.

Г.Мөнхцэцэг: Сая энэ асуултаа ерөөсөө гүйцэд сонсоцгоо л доо. Энэ арай л өөр хариулт өгөөд байх юм. Сангийн сайд нэмээд саяын яг энэ тодотголоор энэ соёлын төвд ажиллаж байгаа энэ бүх хүмүүсийн чинь цалин тэгшитгээд орж ирж байгаа юу гэдэг асуулт асуусан шүү дээ Баярсайхан гишүүн тийм ээ. Хариулчих, Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Энх-Амгалан Төрийн нарийн бичгийн дарга аягүй буруу хариулж байна шүү. Та энэ салбарын хамгийн өндөр төрийн албан тушаалтан байж байж сайдынхаа гаргасан шийдвэрийг шал буруу хариулаад, шал буруу тийм хүлээлт үүсгэх юм. Ганц соёлын салбар ч биш Баярсайхан гишүүн ээ боловсрол, эрүүл мэнд ерөөсөө бүх салбарууд дээр мэргэжлийн үйлчилгээнийхэн бол тухайн салбарынхаа мэргэжлийн онцлогоос хамаараад нэмэгдлүүд авна, авдаг. Харин тухайн салбарын нийтлэг үйлчилгээнийхэн нь бол нэмэгдэл авдаггүй. Ганц соёлын салбар биш. Бүх салбарууд дээр адилхан гэсэн үг. Тийм, орон нутгийн нэмэгдэл авна. 5 жилийн нэмэгдлүүдийг авахгүй байхгүй юу. Орон нутгийн нэмэгдэл чинь өөр шүү Энх-Амгалан сайд аа. Тэгэхээр цаашидаа ч гэсэн энэ бодлого үргэлжилнэ. Өнөөдрийг ч хүртэл ингэж явж ирсэн цаашидаа ч хэвээрээ үргэлжилнэ гэсэн үг.

Өөрөөр хэлбэл тэр хооронд ялгаатай зүйл нь хэвээрээ хадгалагдана л гэсэн үг. Тийм, тэгэхээр энэ жилийн

тодотгол дээр байхгүй. Саяын тэр Энх-Амгалан сайдын хэлчихдэг бол сая энэ жилийн тодотголоос өмнө төсвийн ерөнхийлөн захирагчийн өөрийнхөө хуваарь дотор өөрчлөлт оруулаад, хууль нь батлагдсан байсан ингээд анх удаа хэрэглэж байгаа юм. Тэгээд яг соёлын салбарын мэргэжлийн үйлчилгээнийх нь улсууддаа 5 жилийн нэмэгдлийг нь тавьж өгсөн байгаа.

Г.Мөнхцэцэг: Баярсайхан гишүүн нэмж тодруулж асуулт тавья.

Б.Баярсайхан: Энэ хүнд хэцүү цаг үед бол би их олон юм ярихыг бол хүсэхгүй байна. Гэхдээ дараа дараагийн төсөв, цалин, мөнгөний бодлогодоо энэ соёлын салбарын энэ саяын нэрлэсэн жолооч, харуул, манаач гээд энэ орон нутагт ялангуяа соёлын төвд арын ажлыг хийж байгаа хүмүүс давхар бараг соён гэгээрүүлэх ажил жүжигчний ажлыг хүртэл бараг давхар хийгээд явдаг шүү дээ. Тэгээд энэ хүмүүсээ анхаарахгүй бол бид нар яаж орон нутагт хүмүүсээ соён гэгээрүүлж ер нь төвлөрлийг сааруулъя, орон нутагт нь сайхан амьдруулъя гэх вэ дээ.

Тэгээд Соёлын салбар ер нь жоохон олигтойхон ажилламаар байна. Өнөөдөр Монгол улсад тайзан дээр цирк тоглож байгаа Монголоос өөр улс орон энэ дэлхийд бараг байхгүй байх. Тэгээд энэ соёлын салбарынхаа хэдхэн хүмүүсийг анхаараад өгчихвөл уул нь нөгөө соён гэгээрэх ажил чинь хөдөө орон нутагт илүү чанартай явах юм даа.

Г.Мөнхцэцэг: Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Төсвийн тодотголыг ерөнхийд нь дэмжиж байгаа. Тэгээд бас хэд хэдэн хэлэх болон асуух асуулт байна. Өнгөрсөн хугацаанд боловсрол болон эрүүл мэндийн салбарын хувьд бол төсвийн реформ хийсэн, гүйцэтгэлээр санхүүждэг болсон. Ер нь менежментийн нэлээн том том

өөрчлөлтүүдийг хийж чадсан байдаг. Өөрт байгаа нөөц бололцооныхоо хүрээнд менежментийн сайжруулалт хийгээд тэгээд илүү үр ашигтай төсвийн захиран зарцуулалтын тогтолцоо руу шилжсэн байгаа. Эндээс энэ манай Байнгын хороотой холбоотой ямар 2 салбар үлдэж хоцорсон бэ гэхээр соёлын салбар болон спортын салбар гэж харж байгаа.

Тэгээд соёлын салбарын хувьд болохоор энэний гор нь сая өнгөрсөн хугацаанд болсон энэ жагсаал цуглаан ингээд гарлаа шүү дээ. Энэ соёлын салбартай холбоотой энэ Соёлын яам чинь байгуулагдаад нэлээн удаж байна. Бид нар холбогдох бүх оруулж ирсэн хуулийг нь маш нягт нямбай ажиллаад цаг хугацаанд нь батлаад ингээд явуулж байсан боловчиг яг ийм менежментийн шинэчлэл ерөөсөө хийж чадаагүй ингээж ирсэн нь ерөөсөө сая харагдсан гэж бодож байна л даа. Тэгээд одоо бол ингээд эдийн засаг сайжраад бас Засгийн газар, Сангийн яам ч гэсэн ингээд тодорхой хэмжээнд нэлээн сайн санхүүгийн менежмент хийсний үр дүнд бид нар энэ салбаруудын цалинг нэмэх боломж нь олдож байна.

Гэхдээ цааш цаашдаа энэ соёлын салбар нь өөрөө бас өөр газраас орлогоо бүрдүүлдэг, менежментээ сайжруулж ингээж ажилладаг ийм тогтолцоо руу орох ёстой байгаа. Тэгэхээр Соёлын яам нь энэ дээр яг ийм тогтолцооны реформ хийх, төсвийн үр ашигтай захиран зарцуулалт хийх тийм ажлын төлөвлөгөө та бүхэнд ер нь байна уу гэдгийг нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт энэ цалингийн нэмэгдэл дээр энэ орон нутгийн яг номын санд ажиллаж байгаа хүмүүс, музейд ажиллаж байгаа хүмүүс, соёл урлагийн байгууллагад ажиллаж байгаа хүмүүсийн яг хамгийн доод цалинг нь яг одоо надаа хэд болох вэ гэдгийг хэлээд өгөөч. Энийг бас ингээд салбарынхан сонсох гээд хүлээж байгаа. Мөн спортын салбарт яг

орон нутагт ажиллаж байгаа хүмүүс хамгийн доод тал нь хэдэн төгрөгийн цалин хөлс авах вэ гэдгийг надад яг тодорхой хэлээд өгөөч. Энийг олон хүн сонсох гээд хүлээж байгаа гэж бодож байна.

Бас нэг миний ойлгохгүй байгаа юм нь энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд цалинг тэгишитгэнэ гэж яриад байгаа юм. Ингээж бол ярьж болохгүй. Тэгишитгэнэ гэдэг чинь маш өөр өөр онцлогтой олон янзын салбарын олон янзын мэргэжлийн хүмүүсийг тэгишитгэнэ гэж ярьж болохгүй өөр өөрийн онцлогтой. Жишээлбэл, шинжлэх ухааны салбарт ажиллахын тулд 10 гаруй жил сурч байж энэ салбарт нэг хүрээлэнгийн судлаач болоод ингээд ажилладаг. Энэ хүмүүсийг бас зарим хүмүүстэй тэгишитгэж ингээж авч үзэж ерөөсөө болохгүй гэдгийг хэлмээр байгаа юм. Тэгэхээр энд ялгаа байгаа юу, эсвэл тэгишитгэнэ гэдэг нь яг юугаа та нар яриад байгаа байгаа юм бэ гэдгийг асуумаар байна.

Түрүүн бас энэ боловсролын салбарт нийтлэг үйлчилгээний хүмүүс нь цалин нэмэгдэхгүй гэсэн би ойлголтыг авчихлаа л даа. Тэгэхээр жишээлбэл тогооч, ерөнхий боловсролын сургуулийн номын санч ч гэдэг юм уу ийм ийм ажилтнуудын цалин бас яг нэмэгдэх үү, үгүй юү гэдгийг яг тодорхой хэлээд өгөөч.

Г.Мөнхцэцэг: Тэр соёлын яаманд ер нь ямар шинэчлэл хийх гэж байгаа юм, ямар бодлого байна гээд энэ асуултад Соёлын сайд ирээгүй байна уу тээ. Энх-Амгалан төрийн нарийн бичиг 7 дугаар микрофон дээр суугаад хариулж байя. Ард нь тэр Нийгмийн хамгааллын яамныхан цалингийн нэмэгдэлтэй холбоотойгоор бэлдэж байгаарай асуултад.

Ч.Энх-Амгалан: Ундрам гишүүний асуултад хариулъя. Соёлын байгууллага үндсэндээ 425 байгууллага

үйл ажиллагаа явуулж байна. Энэ хүрээндээ бид нар энэ соёлын байгууллагын удирдлага, менежмент тогтолцоог сайжруулах чиглэлээр ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Зөвхөн төсвөөс хараат бус ажиллах биш өөрийн орлогоо олох ийм нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байгаа.

Сангийн сайдын А74 дүгээр тушаалын хүрээнд бол бусад нэмэлт орлогынхоо үйл ажиллагааг зарцуулах ийм тушаалыг бол одоо яг хэрэгжүүлэх ажил хийгдэж байгаа. Нөгөө талдаа үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог яг боловсролын салбар, эрүүл мэндийн салбарт хэрэглүүлсэнтэй адил энэ жил энэ үр дүнд суурилсан санхүүжилтийг хэрэгжүүлэх чиглэлээр ажлуудыг төлөвлөж ажиллаж байгаа.

Г.Мөнхцэцэг: Цалинтай холбоотойгоор тийм номын санчдын цалин хэдээр нэмэгдэж байгаа юм, музейн ажилчдын цалин ямар байдлаар нэмэгдэж байгаа юм гээд энэ соёл урлагийн байгууллагын ажилчдын цалингийн нэмэгдлийн талаар асуусан асуулт байгаа. Дараа нь тийм спортынхныг бас асуусан байгаа. Эхлээд соёлынхныг. Хэн хариулах юм? 6 дугаар микрофон дээр сайд нар хариулаад явчих уу тээ. Дэд сайд.

С.Зулхар: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ундрам гишүүний асуултад хариулъя. Спортын салбарын албан хаагчдын нэн ялангуяа төрийн үйлчилгээний албан хаагчид, албан хаагчдын үндсэн цалингийн доод хэмжээ сая төгрөг байгаа. Дээд хэмжээ нь үндсэн цалингийнх сая дөрвөн зуун далан дөрөв болж ингэж нэмэгдэж байгаа гэдгийг энд хэлье.

Төрийн нийтлэг үйлчилгээ байгаа юм. Төрийн нийтлэг үйлчилгээний ялангуяа жишээ нь сургуульд ажиллах нийтлэг үйлчилгээний албан хаагчдын

цалин бол 31 хувиар нэмэгдэж байгаа. Энэ бол доод тал нь долоон зуун тавь, дээд тал нь сая хоёр зуун ерэн мянга болж ингэж нэмэгдэж байгаа ийм өөрчлөлт явж байгаа юм.

Төрийн албан хаагчдын ялангуяа төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсний тогтолцоонд бас тодорхой түвшний хувьд реформ хийж байгаа гэж ойлгож байгаа юм. Төрийн үйлчилгээний албыг бид цалин хөлснийх нь бодлогоор бол төрийн мэргэжлийн алба, төрийн нийтлэг жишээ нь үйлчилгээний алба гэсэн байдлаар ингээд 2 үндсэн бүлэг болгосон. Мэргэжлийн алба дотор нь төрийн үйлчилгээний бага, дунд боловсрол, шинжлэх ухаан, мэргэжлийн боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, биеийн тамир, спортыг багтаасан байдлаар ингэж цалингийн жишээ нь тогтолцоог боловсронгуй болгож байна.

Г.Мөнхцэцэг: Хариулт Бат-Эрдэнэ сайд сая спортынхны цалингийн нэмэгдлийн талаар асуулт асуусан юм. Энэ асуултад хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Юуны өмнө Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ингээд энэ цалин, тэтгэвэртэй холбоотой их чухал ийм шийдвэр, бодлого гарч тэгээд энэ төсвийн тодотголоор хэлэлцэж Их Хурал шийдэх гэж байна л даа. Тэгээд энд ер нь энэ салбар болгоны хүмсүүд сэтгэл хангалуун байгаа, баяртай байгаа.

Яагаад гэвэл зарим салбарууд хэт доогуур ийм цалингийн тогтолцоотой байсан. Тэгэхээр энэ цалингийн тогтолцоог нь тодорхой хэмжээнд дээш нь татаж байгаа. Манай биеийн тамир, спортын салбарынх бол дунджаар ер нь 40-62 хувийн ийм нэмэгдэлтэй байгаа. Тухайлах юм бол яах вэ би дундаж албан тушаалтны ажил хариуцаж байгаа хүмсүүдийн жишээ хэлье л дээ. Энэ аймаг, нийслэлийн дүүргийн биеийн тамир, спортын улсын хороонд биеийн

тамирын ахлах арга зүйч, ахлах дасгалжуулагчийн албан тушаал эрхэлж байгаа хүнсний хүний цалин дунджаар 850000- 1330000 мянган төгрөг болж нэмэгдэж байгаа. Тэгэхээр энэ бол 500 орчим мянган төгрөгөөр нэмэгдэж байгаа. Энэ бол сайн нэмэгдэл гэж ингээж ойлгох ёстой.

Нөгөө талынх нь юм өмнө нь Хүрэлсүх Ерөнхий сайдын тэргүүлж байсан Засгийн газар манай энэ улсын шигшээ багийн дасгалжуулагч, тамирчдын цалинг нэмэгдүүлж өгсөн байгаа юм. Тэр тухайлах юм бол яг ажил хариуцаж байгаа энэ албан тушаалтны цалин 800 орчимтой ярьж байхад тамирчны цалин 1200000, дасгалжуулагч нь 1500000-аар ингээж нэмэгдүүлж өгсөн. Одоо бол яг өдөр шөнөгүй энэ биеийн тамирын салбарт ажиллаж байгаа хүмсүүдийн цалин урамшууллыг ингээж нэмэгдүүлж өгч байгаа юм. Би яагаад энэ хариултыг өгөхийн ялдамд би нэг зүйл нэмж хэлэх гээд байгаа нь бол энэ хэвлэл мэдээлэл олон түмэнд хүргэхдээ манай хүмсүүд энэ биеийн тамир, спортын салбарынхны цалин нэмэгдэж байгаа талаар ерөөсөө мэдээлэл өгөхгүй байгаа юм. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас энэ бусад Байнгын хороогоор хэлэлцэгдэж байхад энэ талын мэдээлэл өгөхгүй байгаа юм.

Ер нь бол аль ч түвшиндээ соёл, урлаг спорт гэж хосолмол ийм хэллэгээр нэрлэгддэг байсан бол ингээд сүүлийн жилүүдэд ерөөсөө соёл урлагийн байгууллага, соёл урлагийн салбар гээд ингээд яриад байдаг. Спортын салбарыг орхигдуулчихаад ингээд нэрийг нь дурдахгүй болохоор чинь зэрэг тэр салбарын тухай бодлогын асуудал орхигдоно гэсэн үг шүү дээ.

Гэхдээ энэний ар талд бол энэ өнөөдөр энэ 20 оноос бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурал, Оюун-Эрдэнийн тэргүүлсэн Засгийн газар, цаашилах юм бол улсын Ерөнхийлөгчийн зүгээс энэ биеийн тамир,

спортын нийгмийн ач холбогдолд үнэхээр их анхаарал тавьж, дэс дараалалтай ийм арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа. Өнөөдөр Нийгмийн бодлого энэ манай Байнгын хороо спортын салбар бол энэ бодлогын энэ Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарагдаж байгаа.

Тийм учраас энэ онцгой анхаарал тавьж байгаа явдалд та бүхэндээ баяр талархлаа илэрхийлье. Нийгэмд энэ хүлээлттэй байгаа учраас энэ хүмсүүд мэдээллийг сайн хүргэж өгөөрэй гэж бас энэ хэвлэл мэдээллийнхнээ давхар хүсье.

Г.Мөнхцэцэг: Ундрaм гишүүн тодруулах асуулт. Ундрaм гишүүн нэмж асуулт асууя.

Ч.Ундрaм: Энэ бүх салбарын төрийн албаны цалинг тэгишитгэнэ гэж яг юуг хэлээд байгаа юм бэ? Яг энэ цалинг тэгишитгэнэ гэдэг үгийг жишээлбэл сонсоод, жишээлбэл манай энэ шинжлэх ухааны салбарынхан сонсоод бүүр гайхаад байгаа байхгүй юу Булгантуяа сайд аа. Салбар болгон чинь өөр өөрийн гэсэн онцлогтой. Тэр чиглэлийн мэргэжилд хүрэх гэж бас өөр өөр цаг хугацаа, янз бүрийн байдлаар явж очдог. Одоо жишээлбэл энэ шинжлэх ухааны салбарынхан гэхэд 10 жилээ төгссөөд дахиад 10 гаруй жил сурч байж нэг эрдэм шинжилгээний ажилтан дөнгөж болдог. Тэгээд дөнгөж ингээд шатлал нь явж эхэлдэг. Тэгэхээр энэ салбарыг жишээлбэл өөр салбаруудтай тэгишитгэнэ гэсэн ойлголтыг яриад байгаа юм уу, үгүй юу? Энэ дээр тодруулж өгөхгүй бол миний хойно байдаг дээд боловсрол шинжлэх ухааны салбарын хүмүүс энэ дээр нэлээн их гайхаж.../минут дуусав./

Г.Мөнхцэцэг: Булгаа сайд, Булгаа сайд хариулъя.

Х.Булгантуяа: Яах вэ бид нар энэ удаа Засгийн газраас цалинтай холбоотой авч хэрэгжүүлж байгаа гол

арга хэмжээ бол хөрөөний ир шиг болчихсон байгаа үндсэн цалингийн гол ялгаануудыг жоохон арилгах ийм арга хэмжээ авч байгаа юм. Тэрнээс биш мэдээж энэ чинь салбар болгоны өөрийн онцлогууд, өөрийнхөө холбогдох хуулиудаар, дээрээс нь энэ санхүүжилтийнхээ схемүүдээр явагдаж байгаа. Жишээлбэл эрүүл мэндийн салбарын гэхэд энэ үндсэн цалин. Улсын төсвөөс олгож байгаа үндсэн цалингийн доод хэмжээг сая төгрөг рүү бид нар аваачна гэдэг ийм зорилт шинжлэх ухаан мөн адилхан. Үүнтэй холбоотойгоор шинжлэх ухааны салбарын цалин 41.5 хувь орчмоор нэмэгдэж байгаа Ундрам гишүүн ээ. Энэ нь бүгдээрээ яг адилхан нэг цалинг бүгдээрээ сая төгрөг дээшийгээ, доошийгоо нэг салбар бүгдээрээ адилхан цалин авна гэсэн үг биш. Энэ салбар болгоныхоо ангилал зэрэглэлээр, ангилал зэрэглэлийн хамгийн доод тал хэсэг дээрээ ангилал дээрээ хэд байна гээд тэгээд дээшийгээ ангилал зэрэглэл нь өсөөд явдаг. Үүнтэй холбоотойгоор салбарын яамнуудтай нь энэ ангилал зэрэглэлийг нь тогтоодог. Үүнийг салбарын яамнууд нь угаасаа өмнө нь тогтоочихсон байсан шинжлэх ухааны ангилал зэрэглэлүүд бол яг адилхан явж байгаа. Зүгээр үндсэн цалин эсрэгээрээ жишээ нь шинжлэх ухааны салбар дээр нэмэгдэж орж ирээд хамгийн дээд талын ангилал, зэрэглэл дээр шинжлэх ухааны салбар төрийн мэргэжлийн үйлчилгээ дээр явж байгаа. Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч гэдэг хүний ангилал зэрэглэл бол хамгийн өндрөөр тогтоогдож бас явж байгаа. Одоо энэ ямар бид нар ямар үүднээс энийг хийгээд байгаа юм бэ гэхээр жишээлбэл манай боловсрол дунд, дээд боловсрол дээрээс нь нэмээд эрүүл мэнд гэж байхад зарим салбаруудаасаа доошоо үүнээс нь доошоо ахиад соёл урлаг гээд ингээд хэтэрхий ялгаатай төрийн албаны албан хаагчдын цалингийн үндсэн цалин хэт ялгаатай тогтоосон байж байгааг л бид нар зохимжтой тогтооё гэж л үүнийг гаргаж ирж тавьж байгаа юм.

Тэгэхээр энэ бол шинжлэх ухааны аль нэг салбарыг хөдөлмөрийг багаар үнэлж байгаа биш, төрөөс үнэлж байгаа энэ ажлуудыг нь л үндсэн цалинг нь олгож байгаа үндсэн цалингийн тогтолцоог л илүү их сайжруулж байгаа гэж та бүхэн маань ойлгоорой.

Г.Мөнхцэцэг: Хариулт хангалттай гэж үзэж байна. Асуулт асууж хариулт авлаа. Санал хураалт эхэлбэ.

Төсвийн тодотголын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Энд Цогтбаатар гишүүнээс санал ирсэн байна. Энэ саналын томъёоллыг уншаад танилцуулчихъя. Төслийн 1.1 дүгээр хавсралтын 1.1.65-т сургуулийн барилга 720 суудал Улаанбаатар Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо хэрэгжих хугацаа нь 2019-23 он төсөвт өртөг нь 7 тэрбум 593 сая төгрөгийн төсөвтэй 2023 он санхүүжих дүн нь 1 тэрбум төгрөг байхаар. Мөн үү энэ? Оруулчих юм уу тээ. Уул нь дэгээрээ энэ санал гишүүдийн гаргаж байгаа саналын томъёоллыг хураалгах ёстой тийм. Сая Эдийн засгийн байнгын хороон дээр бас хураалгаад тэгээд ер нь дэмжлэгийг нь хараад л ингээд явчихсан. Энэ зарчмаар дэгээрээ явчихъя тэгэх үү? Тийм. Өөрчлөх гэж байгаа юм биш, нэмэгдүүлэх юутай л юм байна шүү дээ уул нь бол. Цогтбаатар гишүүн манай нэгдүгээрт Байнгын хороо.../ үг тасрав.

Байнгын хорооны дэгээр, хурлын дэгээрээ саналын зөрүүтэй томъёолол гаргасан гишүүний саналыг бол бас санал хураалтаар шийдэх учраас Цогтбаатар гишүүний гаргасан тийм саналыг, саналын томъёоллыг танилцуулчихъя.

Энэ төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.65-д сургуулийн барилга 720 суудалтай Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо, хэрэгжих хугацаа нь 2019-23 он төсөвт өртөг нь 7

тэрбум 593 сая төгрөг гэснийг 2023 оны санхүүжих дүн нь 1 тэрбум 86 төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний 2020 оны санхүүжих дүнг өөрчлөлт оруулахгүйгээр төслийн төсөвт өртөгт 7 тэрбум 593 сая төгрөг гэснийг 10 тэрбум 246 сая төгрөг гэж өөрчлөх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар санал гаргасан байна. Энэ саналыг санал хураалтаар шийднэ. Санал хураалт, санал хураалт, санал хураалт.

Энэ санал дэмжигдсэнгүй. Санал дэмжигдсэнгүй. Энэ санал дэмжигдсэнгүй. Ингээд төсвийн тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийсэн талаар Байнгын хорооны хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн манай Төсвийн байнгын хороонд байдаг гишүүдээс хэн байна. Батиугар гишүүн танилцуулчихъя.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Хуралдаанд оролцсон ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа. Дараагийн хоёр дахь асуудалдаа оръё.

Хоёр дахь асуудал нь ажлын хэсэг байгуулах Байнгын хорооны тогтоол гаргах, тогтоолын төслийг хэлэлцэх байгаа.

15.01 цаг

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг байгуулах байгаа.

Ажлын хэсгийн ахлагчаар уул нь Батиугар гишүүн ажиллахаар байсан. Тэгээд Батиугар гишүүн маань өөрөө бас хүсэлт гаргаад Ундрам гишүүнээр ажлын хэсгийг ахлуулах энэ тохиролцоонд хүрсэн учраас Ундрам

гишүүн ажлын хэсгийг ахалж ингэж ажиллахаар байгаа.

Ажлын хэсгийн гишүүдийг ажлын хэсгийн гишүүдийг тийм санал өгсний дагуу танилцуулчихъя. Ануужин гишүүн, Аубакир гишүүн, Жаргалмаа гишүүн орох уу? Жаргалмаа гишүүн, Мөнхцэцэг гишүүн, Чинбүрэн гишүүн дээр нь нэмж Баярсайхан гишүүн, Батиугар гишүүн хэдэн хүн болж байна? Гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр энэ ажлын хэсгийг байгуулъя. Санал хураалтай шүү гишүүд ээ. Санал хураалтад оролцоорой. Сая ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулсан. Энэ ажлын хэсгийг байгуулж тогтоолын төслийг батлах санал хураалтыг явуулъя. Тогтоолын төслийг. Санал хураалт. Хүрчихсэн хүрчихсэн.

Санал хураалт 80 хувиар дэмжигдсэн байна. Ажлын хэсэг байгууллаа.

3 дахь, 3 дугаар асуудалдаа оръё. Гишүүд байж байгаарай цаглавар санал хураалт байгаа.

15.04 цаг

“Хаврын чуулганы 6 дугаар сард Байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд танилцуулсан байгаа. Тогтоолын төсөлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу? Баярсайхан гишүүнээр. Баярсайхан гишүүн. Нэрээ өгье. Цаглавартай холбоотойгоор асуух асуулттай гишүүд байна уу гэсэн. Баярсайхан гишүүнээр тасаллаа. Энэ техник ерөөсөө сааталтай байгаад байна. Баярсайхан гишүүний микрофоныг өгье. Баярсайхан гишүүний микрофоныг. Дахиад дараад үз дээ микрофоноо.

Б.Баярсайхан: Энэ 6 сард хуралдах Байнгын хорооны хуралд энэ жорлонгийн ажлын хэсгийн дэд ажлын

хэсгийн ажлын явцыг сонсмоор байх юм. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны модон жорлонг орчин үеийн ус, ариун цэврийн байгууламжаар солих энэ ажлын хэсэг одоо яг өнөөдөр ямар түвшинд ажиллаж байгаа юм? 819 сургууль, цэцэрлэгийн дотуур байр, сургуулиас хэд нь баригдчихсан юм, хэд нь баригдах гэж байгаа юм? Чанарын хувьд ямар байгаа юм бэ гэдэг дээр Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар энэ дэд ажлын хэсгээс ажлын тайлан сонсмоор байна, явц сонсмоор байна.

Г.Мөнхцэцэг: Энэ сургуулийн дотуур байрны нүхэн жорлонг солих ажлын хэсэг бол ингээд үндсэндээ 2, 3 жил шахуу ажиллаад тэгээд ажиллаад явж байгаа. Тэгээд энэнтэй хэрэгжилттэй холбоотойгоор гишүүд бас өөрийнхөө тойрогт очиж ажилласан байж байгаа. Ер нь бол бас хангалтгүй гэж зарим нь бас санал, дүгнэлт гаргасан байгаад байгаа.

Тийм учраас энэ асуудлыг бас Байнгын хороо цаглавраар биш тусгай дэгээрээ хуралдаанд оролцуулж энэ сэдвээр энэ асуудлаар тусгайлан ирэх 7 хоногт бас Байнгын хорооны хуралдаанд оруулж ирж бас танилцуулах ийм үүргийг бас яаманд өгсөн байгаа. Тэгэхээр энэ асуудлаар ирэх 7 хоногт Байнгын хорооны хуралдаанд орж танилцуулагдаж бас энэ сэдвээр ярилцана. Энэ сардаа багтаагаад явчихна. Өөр цаглавартай холбоотойгоор алга байна. Ингээд санал хураалт. Санал хураалт.

Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард манай Байнгын хорооноос хэлэлцэх асуудлын цаглаврыг 81.8 хувиар дэмжиж баталлаа.

Санал асуулгад оролцсон гишүүдэд баярлалаа. 3 дугаар асуудалдаа оръё.

15.07 цаг

Хэлэлцэх асуудлын гуравдугаарх нь Биеийн тамир спортын салбарын 2022 оноос 23 оны үйл ажиллагааны талаарх мэдээллийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Бат-Эрдэнэ танилцуулна.

Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны дарга, гишүүд ээ та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооноос манай биеийн тамир, спортын салбарын танилцуулгыг тусгайлан авч хэлэлцэж байгаа. Өмнө нь Дамдинжав дарга мөн Байнгын хорооны даргаар ажиллаж байхдаа энэ биеийн тамир, спортын салбарын талаар их чухал энэ 8 дугаар тогтоолыг гаргаж Засгийн газарт үүрэг чиглэл өгсөн.

Энэ Байнгын хорооноос гаргасан тогтоолын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр тодорхой ажил зохиож гүйцэтгэлийг хангуулж ингэж ажиллаж байгаа гэдгийг би хэлье. Ингээд би товч танилцуулга хийе. Хаанаас удирдаж байгаа билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 8 сарын 31-ний өдрийн шийдвэрээр Олимп, нийтийн Биеийн тамир, спортын үндэсний хороог шинээр байгуулж, Монгол Улсын сайд бөгөөд Үндэсний хорооны даргаар намайг томилсон.

22 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 343 дугаар тогтоолоор Олимпын биеийн тамир, спортын үндэсний хорооны 4 бүрэлдэхүүн сайдын ажлын албаны орон тоо хязгаарыг Засгийн газраас тогтоож өгсөн.

22 оны 11 дүгээр сараас эхлэн Үндэсний хорооны ажлын алба байгуулагдан 5 хүний

бүрэлдэхүүнтэйгээр ажлаа эхлүүлсэн. 23 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн Үндэсний хорооны хуралдаанаар 23 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэж тус төлөвлөгөөнд 7 чиглэлийн нийт 49 арга хэмжээ ажлыг гүйцэтгэхээр ингэж төлөвлөөд ажиллаж байна.

Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны эрхэм зорилгыг бид Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны эрхэм зорилго нь биеийн тамир спортын салбарын эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх, төр, хувийн хэвилийн түншлэлийг бэхжүүлэх, биеийн тамир, спортын хүртээмжтэй, уян хатан үйлчилгээ нэвтрүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар сэтгэл зүрхний, бие бялдрын өв тэгш боловсролтой, бүтээлч тэмүүлэлтэй иргэдийг төлөвшүүлэхэд оршино гэж ингэж тодорхойлсон.

Бид эрхэм зорилгын хүрээнд эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх энэ хүрээнд Биеийн тамир спортын тухай хуулийн өөрчлөлт нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Нийтийн биеийн тамир, спортын салбарын судлаач, багш, дасгалжуулагч, биеийн тамир, спортын зүтгэлтэн, спортын холбоодын төлөөлөл, хуульч, төрийн захиргааны байгууллага зэрэг нийт 16 гишүүнтэй Биеийн тамир, спортын тухай хуулийг шинэчлэх ажлын хэсгийг байгуулан ажиллаж байгаа.

Энэ ажлын хэсгийн хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гаргасан. Улсын Их Хурлаас өргөн барьсан тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, Улсын Их Хурлын Судалгааны хүрээлэнгийн судалгаа, өмнө нь боловсруулсан хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн харьцуулалт, шинжилгээ судалгааны ажлуудыг хийсэн. Спортын холбоодын удирдлага, Үндэсний олимпын хороо, Параолимпын холбоод, аймгийн биеийн тамир спортын хороодын дарга нар, хувийн хэвилийн төлөөлөл, спорт сургуулийн захирлууд

зэрэг 80 төлөөлөл бүхий иргэд байгууллагатай 10 гаруй уулзалт зохион байгуулж одоогоор үйлчилж байгаа хуулийн үр дүн, давуу болон сул үйлчилгээ сул байгаа ийм заалтууд зэрэг асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Өнөөдөр үйлчилж байгаа хуулийн хэрэгжилт үр дүнгийн шинжилгээний тайланг гаргаж мөн гадаадын 10 гаруй улс орнуудын спортын тухай хуулиудыг гүнзгийрүүлэн судалсан. Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн эхний төслийг бэлэн болгосон байгаа.

Эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх энэ зорилгын хүрээнд биеийн тамир, спортын салбарт үйлчилж буй журам стандартын шинэчлэлийг сайжруулах ийм ажлыг хийж байна. Тив дэлхийн наадам болон Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож, медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журамд оруулах өөрчлөлтийг Засгийн газрын хуралдаанаар батлуулсан. Энэ мөн өмнө нь би танилцуулж байсан Дамдинням даргыг Байнгын хорооны даргаар ажиллаж байх үед Байнгын хорооноос гаргасан 8 дугаар тогтоолд тодорхой зааж өгсөн. Энэ журамд өөрчлөлт оруулах ялангуяа энэ тамирчдын сахилга, хариуцлага, ёс зүйтэй холбож энэ шагнаж урамшил олгох энэ журмыг өөрчлүүлэх тухай Байнгын хорооны тогтоолд тов тодорхой зааж өгсөн. Үүний дагуу бид нар боловсруулаад Засгийн газраар хэлэлцүүлж ингэж батлуулж хэрэгжилтийг нь хангаж ажиллаж байна.

Монгол Улсад олон улсад тив дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг шинэчлэх энэ ажил дээр ажиллаж байна. 2003 онд Биеийн тамир, спортын хуулийг батлагдсаны дараа Сангийн яам холбогдох байгууллагууд хамтарч энэ журмыг баталж хэрэгжүүлсэн боловч

бас цаг хугацааны хувьд энэ хэрэгжилт нь бүрэн хэмжээнд хангагдахгүй. Үүнтэй холбоотойгоор шалгуур хангаагүй ийм олон гадаадын тэмцээн уралдаануудыг эх орондоо зохион байгуулах ийм эрх авдаг. Энэ нь улсын төсөвт хүндрэл учруулах, зохион байгуулалтын хувьд олон хүндрэлийг дагуулж байгаа. Тийм учраас энэ журмыг шинэчлэхээр ингэж ажиллаж байгаа.

Нийтийн биеийн тамирын хувьд хувь хүний бие бялдрын хөгжлийг дэмжих идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэхэд өдөр тутмын хөдөлгөөн дасгалын жишиг загварыг хамтран шинээр боловсруулахаар ингэж ажиллаж байна.

Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох, сорилын стандартыг шинэчлэх, сорилын төв байгуулах, санхүүгийн тооцоолол хийх, сорилын цахим сангийн бүрдүүлэлт хийх ийм журмыг мөн шинээр боловсруулж ажиллаж байна.

Спортын тэмцээн зохион байгуулах жишиг заавар Биеийн тамир, спортын улсын хороодтой хамтран боловсруулж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих спортын барилга байгууламжийг аймаг сумдын хүн амын тоо, хэрэгцээ, хүртээмжийг харгалзан боловсруулах аргачлал, спорт заалны барилгын жишиг зураг энэ ажлыг эхлүүлсэн санал аваад энэ 24 оны улсын хөрөнгө оруулалтад бас тодорхой бүтээн байгуулалтын ажлууд хийхээр ингэж ажиллаж байна.

Цаашилбал эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх энэ хүрээнд ёс зүйн зарчмыг нэвтрүүлэх эрх зүйн үндэслэлийг гаргасан Олон улсын олимпын хорооны энэ 21 оны 8 сарын 8-нд шинэчлэн баталсан олимпын харти буюу энэ дүрэмд маш тодорхой заасан.

Нэгдүгээрт, олимпизм бие, сэтгэл, оюун санааны мөн чанарыг

тэнцвэртэй хөгжүүлэх эрхэмлэн дээдлэх амьдралын зорилго, гүн ухаан философи гэж ингэж тодорхойлсон байгаа. Олимпизм маань соёл, боловсролыг хослуулан боловсролын ач холбогдлын үлгэр загвар болж нийгмийн хариуцлага болон нийтээр тогтсон, хүлээн зөвшөөрсөн ёс зүйн зарчмыг хүндэтгэсэн, аз жаргал, баяр баясгалан бялхсан амьдралын хэв маягийг бүтээхийн төлөө үүссэн болно гэж ингэж тодорхойлсон.

Олимпын зорилго хүний мөн чанарыг хамгаалах замаар нийгэмд энх тайвныг тогтоож, хүн төрөлхтнийг эв эе эрхэлсэн, хоорондоо харилцаа шүтэлцсэн, нэгдмэл хөгжил, дэвшлийн төлөө спортын салбар бусад салбараа түүчээлэн ажиллахад оршино гэж ингэж тодорхойлсон. Энэ эрх зүйн үндэс нь бол ингэж тодорхойлогдож байгаа.

Саяхан Улсын Их Хурлаар батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд мөн тов тодорхой зааж өгсөн. Энэ хуулийн 1, 2 дугаар зүйлд энэ хуулийн зорилт нь төрийн албан хаагчийн ёс зүйн үнэт зүйлс, нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг тодорхойлж, түүнийг хангуулах үйл ажиллагааны зохион байгуулалт, журмыг тогтоож, төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

7.1.Төрийн албан хаагч нь үйл ажиллагаандаа доор дурдсан ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин мөрдөнө.

7.1.2.Зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэнэ.

7.1.3.Хууль ёс шударга, ёсыг, дээдлэн сахих, хувийн ашиг сонирхлоос зөрчлөөс ангид байх.

7.1.4.Албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан өөрийн буруутай үйлдэл эс үйлдлийн төлөө ёс зүйн хариуцлага хүлээдэг байх.

7.1.5.Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн хувьд төвийг сахиж, аливаа улс төрийн эвсэл хөдөлгөөн намын нөлөөнөөс ангид байх.

7.1.6.Төрийн албаны захирах, захирагдах ёсыг биелүүлэхдээ энэ хуулиар тогтоосон зан харилцааны нийтлэг шаардлагыг мөрдөх гэж ингэж тодорхойлсон.

Ингээд энэ хүрээндээ бид нар манай биеийн тамирын салбарт эрхлэн сахих, даган мөрдөх ёс зүй И ийм зүйлсийг бид нар тодорхойлсон. Энд бол хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, үзүүлсэн амжилт, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахгүй байх, шударга ёсыг дээдлэх. Спортын талбарт үнэн хичээнгүйлэн өрсөлддөг. Ямарваа нэгэн хууран мэхлэх оролдлого хийдэггүй, шан харамж, бэлэг сэлт, бусад санхүүгийн үр ашиг, үйлчилгээг шаарддаггүй, ийм санал бусдад тавьдаггүй, ийм саналыг хүлээн авдаггүй, шударга бус өрсөлдөөн, худал үг, худал хуурмаг явдалтай эвлэрдэггүй байх, сэтгэл зүй, бие бялдар, ажил мэргэжлийн, бэлгийн аливаа нэгэн шахалт дарамтыг биеэр, үгээр болон цахимаар үзүүлэхийг хатуу цээрлэдэг. Нөхөрсөг зан харилцаа хүний мөн чанарт итгэж, хүн хүнээ хүндэтгэх, ёс жудаг, хүмүүжил, хүндлэл, тэвчээр зэрэг зан үйлийн сайн чанаруудыг дээдэлдэг, бусдыгаа манлайлж хүлээсэн үүргээ гүйцэтгэхдээ шаардлагатай өөрийн ур чадварыг байнга дээшлүүлж, үзүүлсэн амжилт үр дүнгийнхээ төлөө бүрэн хариуцлага хүлээдэг. Өөрийн мэргэжсэн спортын төрлийн хөгжилд хувь нэмрээ оруулдаг, иргэд болон өөр хоорондоо хүндэтгэлтэй, эелдэг харьцаж, нийгэмд биеэ соёлтой авч явах байдлаар үргэлж дуурайлал үзүүлдэг. Олимпизмын үзэл санааг дэмжиж гадаад дотоодын аливаа тэмцээн наадамд оролцохдоо ямагт улс

орныхоо нэр хүндийг эрхэмлэдэг байх. Улс төржсөн аливаа үйлдлээс ангид байх, байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалдаг байх. Бусдын нэр төрийг утган гүтгэн гутаах, доромжлох, хов жив, цуу яриа гарган нийтэд тараах, хүний хувийн амьдрал нууцад үндэслэлгүйгээр халдахыг тэвчдэггүй байх. Спортын цэвэр ариун байдал эрүүл ахуйг үлгэр жишээтэйгээр сахидаг байх. Төрийн хууль ёсыг өөрийн үзэл бодол, ёс суртахуун, үг үйлдлээрээ эрхэмлэн дээдэлж, Монгол Улсын хуулийг хатуу сахин спортын салбарын журам зааврыг даган баримталдаг байх гэсэн ийм И эрхэмлэх ийм зүйлийг боловсруулж энэ эрхэмлэх И ёс зүйн энэ зарчмуудыг Монгол Улсад албан ёсны бүртгэлтэй 80 спортын холбоодод танилцуулахаар санал авахаар бид нар хүргүүлсэн. Цахимаар хүргүүлсэн. Ёс зүйн зарчмыг хэрхэн мөрдөх, спорт сонирхогч иргэдэд түгээх талаар санал авахаар бүх дүүрэг, аймгийн биеийн тамир, спортын хороодод цаасан хэлбэрээр илгээсэн.

Олимпын нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын тушаалаар байгуулсан Биеийн тамир спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал бэлдэх үүрэг бүхий ажлын хэсэг эдгээр эрхэмлэн дагах ёс зүйн зарчмыг хуулийн төсөлд оруулахаар ажиллаж байгаа. Энэ шинээр боловсруулж байгаа хуулийн төсөл, биеийн тамир, спортын ёс зүйн зарчим, биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хүрээнд, Биеийн тамир, спортын ёс зүйн орон тооны бус үндэсний зөвлөлийг байгуулах. Үндэсний зөвлөлийн ажиллах дүрмийг батлан мөрдүүлэх, спортын холбооны чиг үүрэг, ёс зүйн дүрмийг олон улсын дүрэмд нийцүүлэн батлах, Спортын холбооны ёс зүйн зөвлөл байгуулж бүрдүүлэх, Ёс зүйн үндэсний зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх, ёс зүйн зарчим зөрчсөн тохиолдолд гомдлын дагуу Ёс зүйн үндэсний зөвлөл хэлэлцэн шийдвэрлэх. ЮНЕСКО байгууллагад хандан спортын салбарт ёс зүйн хэм

хэмжээг тогтоох олон улсын туршилага, хамтын ажиллагаа, төсөл хэрэгжүүлэх санал боловсруулан хүргүүлсэн байгаа. Албан ёсны бүртгэлтэй 80 спорт холбоодоос судалгаа авч байна. Тухайн спорт холбооны ёс зүйн дүрэмтэй эсэх, Ёс зүйн зөвлөл ба түүний ажиллах журам, ноогдуулах шийтгэл, ёс зүйн зөрчлийн талаар тоон баримт, статистик мэдээ гаргаж ирүүлэхээр ингээж ажиллаж байна.

Манай Үндэсний хорооноос хийсэн нэг тулгамдсан ажил бол энэ допингийн эсрэг үндэсний дүрэм байгаа юм. Энэ ажил авах үед бол олон улсын допингийн эсрэг байгууллага буюу (WADA)-аас манай улсад хатуу анхааруулга өгчихсөн ийм хүнд нөхцөл байдалтай 10 сарын 6-наар тасалбар болгож, хэрвээ үндэснийхээ дүрмийг батлахгүй бол Монгол Улс 24 оны Парисын олимпод цагаан тугийн доор олимпод оролцох эрхгүй болохоор ийм нөхцөл байдалтай байсан.

Тийм учраас Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж энэ 376 дугаар тогтоолоор допингийн эсрэг үндэсний дүрмээ баталсан. Олон улсын допингийн эсрэг (WADA) байгууллагатай хамтран ажиллаж үндэсний дүрмийн жишиг загварыг монгол хэл рүү орчуулсан. Манай орны нөхцөл байдалд тохируулж эндээс чиглэл авч энэ ерөөсөө бусад улс орнууд ч гэсэн ингээж үндэснийхээ дүрмийг баталдаг. Монголын холбогдох спорт, эрүүл мэндийн байгууллагатай хамтран Допингийн эсрэг үндэсний зөвлөл тогтолцоо энэ платформыг байгуулах энэ том ажлыг эхлээд байгаа. Допингийн эсрэг дүрмийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, сайдын тушаалаар батлуулсан. Энэ оролцогч тал бол Биеийн тамир, спортын улсын хороо, Монголын допингийн эсрэг байгууллага, Монголын үндэсний олимпын хороо, Монголын олон улсын спортын арбитр Монголд байгуулагдаад ингээд үйл ажиллагаа нь жигдрээд явж байгаа.

Төр, хувийн хэвилийн түншлэлийг бэхжүүлэх чиглэлээр бид өмнө нь бол ийм уулзалт хэлэлцүүлэг хийж байгаагүй. Тэгээд энэ хэлэлцүүлгийг бид амжилттай хийсэн. Нийтийн эрүүл мэнд идэвхтэй хөдөлгөөнийг дэмжихэд эрүүл мэндийг болон спортыг дэмжих тусгай сангуудын ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх нэмэлт эх үүсвэр бүрдүүлэхэд чиглэсэн Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулах ийм хуулийн төслийг бид бэлдсэн байгаа.

Электрон болон бусад төрлийн утаат ус, тамхи, казиногийн үйл ажиллагаа, бооцоот таавар, бооцоот морин уралдаан, хонжворт сугалаа, энэ орлогод ноогдуулах онцгой албан татварын зарим хэсгийг Нийтийн биеийн тамирыг дэмжих сангийн санхүүгийн эх үүсвэр болгон татан төвлөрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх судалгааны ажлуудыг эхлүүлсэн.

Улсын хилээр нэвтрүүлэх спортын хэрэглэл, хувцас, тоног төхөөрөмжийг НӨАТ-аас чөлөөлөх энэ асуудлыг холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар бид бэлтгэл хангаж, ингээж ажиллаж байна. Монгол Улсад Олон улсын олимпын хорооны стандарт, шаардлагад нийцсэн спортын барилга байгууламж барьсан болон шинээр барьж буй энэ хувийн хэвилийн хөрөнгө оруулалт, энэ аж ахуйн нэгж үйл ажиллагаанд дэмжлэг, хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх саналыг хүлээн авч бас мөн энэ судалгааны ажлыг хийгээд ингээд ажиллаж байгаа. Энэ биеийн тамир, спортын салбарт бүх асуудлыг дандаа төсвийн санхүүжилтээр хийх ийм боломж бол хязгаарлагдмал байгаа гэдгийг танилцуулъя.

Цаашилах юм бол итгэлтэй дасгал хийх, спортоор хичээллэх энэ барилга байгууламж заал талбайг өргөжүүлэх чиглэлээр томоохон ажлууд эхлээд явж байна.

Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Ерөнхийлөгчийн нэрэмжит ийм Залуучуудын спорт сургалтын цогцолборын ажил эхлээд явж байна. Энэ “Президент” спорт цогцолборын зураг төсвийг Барилга, хот байгуулалтын яамнаас бүрэн хэмжээнд боловсруулсан хотын холбогдох байгууллагуудтай инженерийн шугам сүлжээ, газар, угсрах зөвшөөрөл бүх зөвшөөрөл нь гарсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Бүгд Найрамдах Хятад Ард Улсад айлчлах үеэрээ 2 орны Ерөнхийлөгч нар тохирч, энэ том хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ингээд энэ ажил бол хөтөлбөрийн дагуу явж байна. Энэ том цогцолборын бэлтгэлийг хангуулах ажлын хэсгийн ахлагчаар Ерөнхий сайдын захирамжаар миний бие энэ ажлын хэсгийг ахлаад ингээд ажиллаж байгаа.

Цаашлах юм бол мөн Хятадын ард түмний тусламжаар баригдсан Буянт-Ухаагийн спорт цогцолборыг мөн Хятадын Засгийн газрын 30 тэрбум төгрөгийн тэнцэх хэмжээний ийм хөрөнгө оруулалтаар иж бүрэн их засвар хийсэн. Энэ 8 сард ашиглалтад оруулахаар ингээд улсын комисст хүлээж авахаар ингэж ажиллаж байна.

Цаашлах юм бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай тоног төхөөрөмж бүхий спорт цогцолборыг төслийг эхлүүлэхэд гадаадын хамтрагч байгууллагатай гэрээ хэлэлцээр байгуулах ажил хийгдэж байна. Цаашилбал 2023 онд 2 дүүрэг, 15 сумын спорт цогцолбор, заалыг ашиглалтад оруулна.

Энэ хөдөө орон нутгуудад болоод сумдад хийгдэж байгаа биеийн тамир спортын энэ томоохон цогцолборын ажлуудад манай Улсын Их Хурлын гишүүдийн санаачилгаар энэ том

зорилтууд хэрэгжиж байгаа гэдгийг хэлье.

Иргэдийн бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох сорилын төвүүдийн сүлжээ байгуулах энэ том зорилтыг Бүгд Найрамдах Солонгос Улсын жишигээр байгуулахаар бид зорьж байгаа. Иргэдийг идэвхтэй хөдөлгөөн хийх аргачлалын загвар боловсруулах, үүрэг бүхий 2 ажлын хэсэг шинээр байгуулж ажлаа эхлүүлээд байгаа. Энэхүү сорилын төвийн сүлжээг улс орон даяар нэвтрүүлснээр дараах бодит үр дүн гарна гэж тооцоолж байна.

Нэгдүгээрт, Сорилын төв нь хүний биометрийн үзүүлэлт болон бие бялдрын түвшнийг зориулалтын тоног төхөөрөмжийн тусламжтайгаар хэмжиж, сорилын үнэлгээнд суурилсан хувь хүнд тохирсон дасгалын жор, зааврын дагуу зөвлөгөө өгөх, бие бялдрын түвшин доогуур иргэдэд чиглэсэн биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг зааж чиглүүлсэн үйлчилгээ үзүүлдэг болно.

Иргэд сорилын үр дүнтэй холбоотойгоор өөрт шаардлагатай мэдээлэл, зөвлөмж, зөвлөгөөг цахим сангаар дамжуулан ашиглах нөхцөл бүрдэнэ. Иргэдийн нас, хүйс, амьдралын хэв маяг зэрэг мэдээллийг агуулсан бие бялдрын сорилын үзүүлэлт бүхий үндэсний хэмжээний дата сан бүрдэнэ.

Уг сан бий болсноор нийтийн биеийн тамирын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох мэдээллийн бодит эх сурвалжтай болно. Нийтийн биеийн тамирын ажилтнууд нийтийн салбарын үйл ажиллагааны үр дүнг бодитойгоор тооцож дүгнэх ийм нөхцөл бүрдэнэ гэж ингэж зорьж ажиллаж байгаа.

Цаашлах юм бол спорт эрдэм шинжилгээг хөгжүүлэх чиглэлээр ажлууд хийгдэж байна. Монгол Улсын спортын шинжлэх ухааны өнөөгийн түвшин ба орчин үеийн спортын шинжлэх ухааны хөгжил сэдэвт эрдэм шинжилгээний

хурлыг 22 оны 12 сарын 22-ны өдөр зохион байгуулсан.

Энд бие биеийн тамирын бүх дээд сургуулиуд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, спортын 5 холбоод, хоол зүйчдийн холбоо зэрэг 12 байгууллагын 70 гаруй эрдэмтэн багш, судлаач, спортын салбарын зүтгэлтнүүд, мэргэжилтнүүд оролцсон.

Спортын шинжлэх ухааны орчин үеийн чиг хандлага, спортын шинжлэх ухаанд суурилсан бэлтгэл, дасгалжуулалт, спортын анагаах ухаан, спортын хоол зүй, спортын сэтгэл зүй, спортын био механик зэрэг 6 сэдвээр 19 илтгэлийг хэлэлцэн 24 илтгэлийг цахим илтгэл хэлбэрээр оролцогч нарт цахимаар түгээсэн байгаа.

Биеийн тамирын боловсрол ба спортын хөгжил олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 23-ны 4 сарын 11-ний өдөр зохион байгуулсан. Энэ хуралдаанд Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Казакстан, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 15 эрдэмтэд оролцсон. Нийтийн биеийн тамир, спортын сургалт, спортын маркетинг ба менежментийн сэдвээр 29 илтгэлийг хэлэлцүүлсэн.

Биеийн тамир спортоор хичээллэгч иргэдэд зориулсан дасгалын жишиг загвар, төслийн хүрээнд судалгааны аргачлал боловсруулж хамаарах иргэдийн бүлэг нас, хүйс, амьдралын хэв маяг, байршилыг тогтоож, хөдөлмөрийн насны 10000 орчим иргэдээс сорил, шинжилгээ авах бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.

Орон нутгийн өсвөрийн тамирчдын бие бялдрын ерөнхий хөгжлийн судалгааг 22 оноос хойш үргэлжлүүлэн авч хийгээд ингээд явж байна. Үүгээр өсвөрийн тамирчдын ажиллах чадвар, булчингийн бүтцийг

тодорхойлох цогц сорьц шинжилгээ авч, аймгуудын дасгалжуулагч нарт өсвөр насны хүүхдийн физиологийн онцлог, бэлтгэл дасгалжуулагч, төлөвлөлт, гэмтлийн дараах яаралтай авах арга хэмжээ, ТЭП гэж ярьдаг боолт тамирчдын энерги, хангамж зэрэг чиглэлээр зөвлөмж өгч ингээж ахаиллаж байгаа.

22-23 онд манай спортын онцлох амжилтууд их сайн байгаа. Улсын Их Хурал, Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа энэ дэмжлэг бодитой арга хэмжээний үр дүнд манай тамирчдын амжилт сайн байна. Тухайлах юм бол энэ Дэлхийн аварга шалгаруулах хоккейн тэмцээнээс манай тамирчид мөнгөн медаль авсан. Дэлхийн аварга шалгаруулах эмэгтэйчүүдийн боксын тэмцээн, эрэгтэйчүүдийн боксын тэмцээнээс Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс түүхэндээ хос медалийг, мөнгө, хүрэл медалиудыг бас авсан байгаа.

Цаашлах юм бол энэ ази тивийн аварга шалгаруулах 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнээс манай тамирчид алтан медаль авч байгаа. Мөн Дамдинням дарга тусгайлан баяр хүргэхгүй бол болохгүй. Энэ багийн спортыг хөгжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт тавьж зүтгэж байгаа. Ялангуяа энэ сагсан бөмбөгийн лигийн тамирчдын сахилга ёс зүйтэй холбоотой 3х3 багийн тамирчдын хамтын ажиллагааг бэхжүүлэх, энэ спортын холбоодын Олон улсын олимпын хартиар бидэнд үүрэгжүүлсэн байгаа энэ ёс зүйн дүрэмтэй болох, Ёс зүйн зөвлөлийг ажиллуулах ийм чиглэлээр үлгэр жишээ болж ажиллаж байгаа явдалд бас тэмдэглэж хэлэх ёстой.

Ази тивийн аварга шалгаруулах энэ мөсний хоккейн өсвөр үеийн 18 тэмцээнээс манайхан багаараа хүрэл медаль авсан ийм сайхан амжилттай явж байна.

Парис-2024 олимп, Параолимпын наадмын бэлтгэлийг ажлыг хангах энэ хүрээнд ажил бол сайн явж байгаа. Бүх Монгол Улсын Ерөнхий сайдын 23 оны 1 сарын 25-ны өдрийн 83 дугаар тоот тогтоолоор Засгийн газрын тогтоолоор Парис-2024 олимп, Параолимпын бэлтгэлийг хангах үндэсний хороог шинээр байгуулж бүрэлдэхүүнийг баталсан.

Үндэсний хорооны үйл ажиллагааны дүрэм, төлөвлөгөөг үйлдэж олимп, параолимп, дэмжих сангийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Парис-2024 олимп, параолимпын наадамд оролцох шигшээ баг спортын 26 төрлийн 286 тамирчин, дасгалжуулагч, 23 оны шигшээ багийн нийт төсөв 10.8 тэрбум төгрөг, 22 онд зарцуулсан хөрөнгө мөнгөнөөс хамаагүй нэмэгдүүлж өгсөн байгаа. Энэ 23 оны төсөвт Их Хурал та бүхэн маань бусад салбарын яамдын төсөв бол урд жилүүдийнхээ хэмжээнд эдийн засгийн байдлаас болж царцсан бол манай биеийн тамирын салбар ялангуяа энэ олимпын эрх авах 23 оны энэ тэмцээн уралдаануудад анхаарал тавьж энэ миний дээр хэлж байгаа 10 тэрбум төгрөгийг нэмэгдүүлж өгсөн.

Энэ 23 онд манай олимпод оролцох спортын төрлүүдээр нийт 45 тэмцээнд оролцох ийм учиртай. Тэр Засгийн газрын тогтоолын юу байна. “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын энэ томоохон хөтөлбөр дэвшүүлсэн. Энэ хөтөлбөрийн хүрээнд идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир спортын ээлтэй орчныг бүрдүүлэхээр ингэж заасан. Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Эрүүл Монгол хүн хөтөлбөр, Засгийн газраас энэ жилдээ эрүүл жиндээ цаг гаргая ийм томоохон хөтөлбөрүүдийг дэвшүүлсэн. Энэ хөтөлбөрийг гол гардаж ажиллах хүмсүүд бол манай биеийн тамирын салбарын аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамирын хорооны алба хариуцаж байгаа хүмсүүд, цаашилах юм бол спортын холбоод, клуб,

нийгэмлэгүүд, идэвхтэн, зүтгэлтнүүд бид бүгдээрээ хамтарч ажиллах ёстой.

Тийм учраас биеийн тамир спортын салбарынхан энэ 4 сарын 1-нээс он дуустал эерэг хандлага, эрүүл нийгэм энэ аянд хамтдаа нэгдэж, энэ Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн Эрүүл Монгол хүн хөтөлбөр, Засгийн газраас дэвшүүлж байгаа илүүдэл жингүй эртэч Монгол хүн, энэ эрүүл Монгол хүнийг бий болгох энэ том хөтөлбөрт бид хамтарч ажиллаж байгаа.

Бид хамтдаа дэвшүүлсэн эерэг хандлага, эрүүл нийгэм энэ аянд маш олон байгууллага, хамт олон, спортын клуб, нийгэмлэгүүд, тамирчид, идэвхтэн зүтгэлтнүүд нэгдэж байгаа. Нийт хандалтын тоо бол 2 сарын хугацаанд гэхэд давхардсан тоогоор 864447-д хүрсэн ийм үр дүнтэй явж байна.

Монгол Улсад энэ 2023 онд зохион байгуулагдах спортын тэмцээн наадмын талаар та бүхэндээ танилцуулъя. Дараагийнхыг нь явуулаарай. Энэ тэмцээн, одоохон дууслаа. Энэ тэмцээнүүд бол Монголын бүх ард түмний спортын өвлийн ийм наадмууд Эрдэнэт хотод амжилттай зохион байгуулсан байгаа. Монголын хүүхдийн спортын 7 дугаар наадам зохион байгуулна. Баянхонгор аймагт энэ 6 сарын 19-нөөс эхэлнэ. Энэ том тэмцээн болон дотоодын тэмцээнүүд бид түрүүн танилцуулсан Дэлхийн аварга шалгаруулах хоккейн тэмцээн амжилттай зохион байгуулсан. Азийн аварга шалгаруулах энэ өсвөр насны U18 Азийн тэмцээн амжилттай зохион байгуулж манайх багаараа энэ 2 тэмцээнээс амжилт, медаль авсан байгаа. Энэ 7 сард Улаанбаатарын их дуулга буюу Гранд Слам жүдогийн том тэмцээн зохион байгуулагдана. Аэробик гимнастикийн Азийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдана. Туялзуур жадны Улаанбаатар 2023 Азийн аварга шалгаруулах тэмцээн, мөн тун удахгүй Жюү жицүгийн Дэлхийн аварга

шалгаруулах тэмцээн Монголд зохион байгуулагдана. Ингээд 8 сард Зүүн азийн олимп буюу Зүүн азийн залуучуудын томоохон наадам зохион байгуулагдана. Энэ тэмцээн, уралдааныг зохион байгуулах шийдвэрийг энэ бараг 10 жилийн өмнө буюу 2014 онд шийдвэр нь гарчихсан. Ингээд хэд хэдэн Засгийн газар, хэд хэдэн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанд ингэж явагдаж байгаад яг энэ жилийн 8 сард зохион байгуулагдана. Энэ бол нэг Засгийн газар юм уу, нэг ерөнхийлөгчийн бүрэн эрхийн асуудал биш. Энэ бол Монголын асуудал болсон учраас энэ олон улсын ийм хариуцлагатай олимпын тэмцээнийг бид өөрийн эх орондоо амжилттай зохион байгуулах ийм шаардлага тулгарч байгаа.

Тийм учраас манай Байнгын хороо өнөөдөр энэ төсвийн тодотголоор энэ тэмцээн уралдааныг зохион байгуулахад шаардлагатай байгаа 10 тэрбум төгрөгийн асуудлыг та бүхэн маань шийдэж өгч байгаа. Төсвийн тодотголоор энэ 24.7 тэрбум төгрөгийн асуудлыг та бүхэн маань шийдэж өглөө шүү дээ. Энэ хүрээнд энэ том тэмцээний асуудал явагдаж байгаа гэдгийг танилцуулъя.

Нийтийн биеийн тамир, спортын салбарын санхүүжилттэй холбоотой юмнууд байгаа. Энэ график юм байж байгаа. Энийг та бүхэн маань харна биз. Энэ миний тэр саяын тэмцээн, уралдааны санхүүжилттэй холбоотой ийм асуудлууд байна. Яах вэ энэ салбарыг хариуцсан сайдын алба байгаагүй учраас өмнө нь бол тухайлах юм бол энэ 23 оны улсын төсөвт зайлшгүй шийдэх ёстой энэ хөрөнгө санхүүг нь шийдэж чадаагүй 23 оны төсөв батлагдсан ийм зүйл бий.

Тийм учраас энэ гарцаагүй санхүүжүүлэх шаардлагатай ийм асуудлуудыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс шийдвэрлээд явж байгаа. Тухайлах юм бол, энэ 22 оны олон улс, тив дэлхийн тэмцээнд амжилттай

оролцсон тамирчдын 1 удаагийн мөнгөн шагнал гэхэд 492, 500 шахам сая төгрөгийг шийдүүлж байна. Тэгээд уран гулгалтын тэмцээн, ингээд хөрөнгө мөнгийг нь шийдэж байгаа. Тухайлах юм бол энэ чөлөөт бөхийн холбооны эрэгтэй, эмэгтэй баг дэлхийн цомд Америкт оролцсон. Энэ тамирчдын онгоцны зардлын мөнгө нь төлөгдөөгүй байсан 215 сая 800 мянган төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж байгаа. Манай энэ спортын холбоонуудын хөрөнгө санхүүтэй холбоотой юмыг бид бол ингээд л бүрэн хэмжээнд шийдвэрлээд яваад байгаа гэдгийг би бас та бүхэндээ хэлж дуулгах нь зөв байх гэж ингэж бодож байна.

Энэ төсөвтэй холбоотой юмнууд байна. Та бүхэн маань харна биз. Улсын хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний ангиллуудыг бас та бүхэнд харуулж байна.

5 минут нэгэнт танилцуулж байгаа юм чинь Байнгын хороон даргаа. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлтэй холбоотой ийм энэ аймаг, орон нутаг, нийслэл, дүүргүүдэд бид нар бас Улсын Их Хурлаас шийдвэр гаргаад нийслэлийн 9 дүүрэг, нийт 21 аймагт спортын заалнуудыг нь спортын ордон болгоно. Нийслэлийн 9 дүүргийн Спортын ордныг 1000-аас доошгүй хүний суудалтай ийм усан бассейнтай ордон барьж байгуулах ийм шийдвэрийг бид нар 2008-12 оны Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд бид нар шийдвэр нь гарсан. Тэгээд энэ шийдвэрийн хэрэгжилт бол зарим талаараа хангалтгүй явж байгаа. Одоогийн байдлаар жишээлэх юм бол Налайхын юу бол ашиглалтад орохоор ингээд бэлтгэл хангаж байна. Баянзүрх дүүрэг бол хэцүү. Хан-Уул дүүрэг бол газраас доороосоо ус гарсан учраас тэр хэрэгжих бололцоогүй болсон. Энэ Сүхбаатар дүүргийн спортын ордон бол газрын маргаантай Монгол улсын их сургуулийн харьяа эзэмшлийн газар дээр барьчихсан ийм маргаантай байж байгаа.

Мөн энэ Буудлагын спортын төв, батлан хамгаалах туслах нийгэмлэгийн барилга байгууламж сургалтын төвийн энэ асуудлуудыг Байнгын хорооны дарга Мөнхцэцэг дарга өөрийн биеэр очиж газар дээр нь бид нар үзэж танилцсан. Энэ чиглэлийн ажлууд бол хийгдээд ингээд явж байгаа гэдгийг хэлье.

24 оны шинэ хөрөнгө оруулалтын бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд манай Их Хурлын гишүүд энэ орон нутагтаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд ихээхэн анхаарч байгаа. Энд бас тусгайлан баярлаж талархал дэвшүүлэх нь зүйтэй гэж ийм зүйлүүдийг л та бүхэндээ танилцуулъя даа ямар ч байлаа гэсэн. Манай биеийн тамирын салбарт хийгдэж байгаа ажил бид энэ Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний энэ их том салбарын ажлыг хариуцаж ингэж ажиллаж байгаагийн хувьд манай Үндэсний хороо, Биеийн тамирын хороо бусад Монголын үндэсний олимпын хороо, спортын холбоонуудтайгаа хамтраад энэ том ажил, үүргийг биелүүлээд явж байгаа гэдгийг бас хэлж танилцуулах нь зүйтэй байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Мааш дэлгэрэнгүй танилцуулга хийсэн Бат-Эрдэнэ сайдад баярлалаа. 30 минут сонслоо. Тэгээд бас цаасаар манай гишүүдэд мааш дэлгэрэнгүй танилцуулгууд бас хүрчихсэн байгаа учраас гишүүд өөрсдөө бас энэ цаасаар хүргэгдсэн танилцуулгаасаа мэдэх мэдээллүүдийг авчих ийм боломж бас байгаа гэж ингэж хэлье. Бат-Эрдэнэ сайд баярлалаа.

Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор Байнгын хорооны хуралдаанд оролцогчдын нэрсийг бас танилцуулчихъя. Биеийн тамир, спортын үндэсний хорооноос бас төлөөлөл ирсэн байгаа. Тэмүүжин Олимп, биеийн тамир, спортын үндэсний хорооны ажлын албаны дарга Тэмүүжин ирсэн байна. Биеийн тамир, спортын улсын хорооны

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Гэрэл хүрэлцэн ирсэн байна. Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Цэрэнболд ирсэн байна. Биеийн тамир, спортын улсын хорооны Үндэсний шигшээ багийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Билигт ирсэн байна. Ийм бүрэлдэхүүнтэй энэ хуралдаанд оролцож байна.

Ингээд өнөөдрийн танилцуулгатай холбоотойгоор, хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу? Баярсайхан гишүүн Дамдинням гишүүнээр тасаллаа.

Баярсайхан гишүүн асуулт асууя.

Б.Баярсайхан: Ингээд Монгол Улсад бас энэ биеийн тамир спортыг хөгжүүлэхэд онцгой анхаарч өнөөдөр яамны дэргэд байсан энэ нэг салбарыг Биеийн тамирын үндэсний хороо болгоод бас салбарын сайдтай болгоод ингээд явж байгаад талархалтай байдаг. Засгийн газрын үйл ажиллагааны 20-24 оны үйл ажиллагааны хөтөлбөрт миний бие өөрөө тусгуулсан I том зорилт байгаа. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд танай хороо яаж юу хийх гэж байна яаж ажиллаж байна? Ерөнхий сайд болон Засгийн газартаа энэ асуудлыг яаж ойлгуулах юм бэ? Энэ ямар ажил гэхээр 20-24 онд бүх Монголын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг биеийн тамирын хичээлийн хэрэгслээр мөн хөгжмийн хичээлийн хөгжмийн зэмсгээр бүрэн хангана гэдэг ийм зорилт тусгуулсан. Өнөөдөр та бүхэн маань Үндэсний хороо болж байгуулагдсанаасаа хойш ялангуяа энэ хөдөө орон нутгийн сургуулиудын биеийн тамирын хичээлийн хэрэгсэл, гадаад, дотоод талбай ямар хэмжээнд байгааг ер нь мэдэж байгаа юу? Энэ зорилтыг хэрэгжүүлж улсын төсөв дээр энэ биеийн тамирын хичээлийн хэрэгслийг бүх үндэсний хэмжээнд сургууль, цэцэрлэгт хангах, биеийн тамирын

хичээлийг заах тэр багш, багшийг мэргэжлийн хүнээр бэлтгэх, энэ биеийн тамирын хичээлийг чанартай энэ сургалтыг чанартай болгоход яг одоо юу хийж байгаа вэ.

Яагаад гэвэл өнөөдөр хөдөө орон нутагт мэргэжлийн биеийн тамирын хичээл ийм багш нар дутуу байгаа. Заал, танхим хэцүү байна. Сая хөрөнгө оруулалт хийх гэж байгаа аймаг, орон нутгуудыг харлаа манай Завхан аймаг лав харагдахгүй байна. Тэгээд энэ хугацаа нь дуусчихсан нурж унах гэж байгаа энэ зааланд энэ хичээл хийж байгаа хүүхдүүдийн асуудал, хүүхдүүдийн аюулгүй байдлын асуудлыг юу гэж харж байгаа юм? Биеийн тамирын хичээл гэдэг бол өнөөдөр хүүхдүүдэд хамгийн их тэсвэр хатуужлыг олгох, тэр сайн зан чанартай тэсвэртэй, суурьтай ийм хүү зан чанарыг төлөвшүүлэх, эрүүл байлгах, бие бялдрын хүмүүжил олгох, шударга энэ өнөөдрийн энэ цахим орчинд энэ лайк, коммент дээр унаж босоод байгаа энэ сул дорой сэтгэлийн тэнхээгүй хүүхдүүдийг сэтгэлийн тэнхээтэй болгох, ямар нэгэн байдлаар гомдол хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг эргүүлээд бусдыг уучилдаг, аливаа даваа нугачааг даван гардаг өөрөөр хэлбэл амьдралд тэмцэлтэй, өрсөлдөх чадвартай ийм хүчтэй Монгол иргэдийг бэлтгэх хамгийн гол хичээл байгаа гэж ингээж харж байгаа.

Тэгээд өнөөдөр бодлогын хэмжээнд бас энэ танилцуулга дээрээ харахад нэлээн том том ажлуудыг хийгээд байна. Яг энэ суурь болсон хүүхдүүдэд хандсан, хүүхдүүдийг багаас нь спортлог болгох энэ асуудалд та нар маань юу хийх гэж байна, юу хийж байна гэдэг дээр тодорхой хариулт авъя. Баярлалаа.

Баярсайхан гишүүний асуултад Бат-Эрдэнэ сайд хариулах уу? Бат-Эрдэнэ сайдын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа.

Баярсайхан гишүүн их чухал асуудлыг хөндөж ярьж байна. Тэгэхээр зэрэг яг энэ бол би түрүүн хэллээ аймаг, нийслэлийн спортын ордон, спортын заалыг өргөжүүлэх, шинэчлэх, аймгуудын спортын заалыг спортын ордон болгох ийм зорилтыг хэрэгжүүлсэн. Энэ хүрээндээ бид нар Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын заалны стандартыг шинэчлэх ийм зорилтыг тавьж хэрэгжүүлсэн. Энэ хүрээндээ би СӨБ-д буюу цэцэрлэгт биеийн тамирын багшийн орон тоо бол байхгүй байсан, дуу хөгжмийн багшийн орон тоо бий.

Тийм учраас бид хуульд өөрчлөлт оруулаад, цэцэрлэгт биеийн тамирын багшийн орон тоог бий болгосон. Ингээд ажиллаж байна. Энэ стандартыг нь тодорхой болгохгүй бол үнэхээр болохгүй. Тийм учраас би дахиад хэлэхэд энэ ажилд өмнө нь Улсын Их Хурал дээр би энэ 2004 оноос хойш Биеийн тамир, спортын энэ лобби бүлгийг албан бус лобби бүлгийг ахлан ажиллаж байхад энд хамаг ажлыг хэн нугалдаг вэ гэхээр үе үеийн парламентын Их Хурлын гишүүд маань л энэ ажлыг нугалдаг. Их Хурлын гишүүд маань л сумын ерөнхий боловсролын сургуульд спортын заал, техник тоног төхөөрөмж, хэрэглэл, цаашилах юм бол аймагтаа ингээд шат дараалалтайгаар ийм арга хэмжээнүүдийг л авдаг. Тэгээд тийм учраас манай Баярсайхан гишүүн бол санаачилгатай ажилладаг ийм гишүүн учраас бид нар Баатарбилиг гишүүн хэд хэдэн гишүүдтэй 24 оны төсвийн хөрөнгө оруулалтын саналыг чинь бол энэ 5 сард авч байгаа шүү дээ. Тийм учраас энэ авахаас нь өмнө би түрүүн танилцуулгадаа хэлсэн энэ биеийн тамир спортын жишиг зургийг бид нар гаргачихсан. Өмнө нь бэлтгэгдсэн ямар хэмжээнд байх вэ. Энэ бол зөвхөн сум нь төдийгүй аймаг энэ төвлөрсөн газруудад ийм стандартын заал барих тийм жишиг зургуудыг өгчихсөн байгаа. Энэ зураг дээрээс та бүхэн маань санал аваад ингээд 24 оныхоо хөрөнгө оруулалт дээр

та бүхэн минь одоо сумдаа, аймагтаа ядаж 2, 3 сумд энэ спортын цогцолбор барих ийм санаачилгыг та бүхэн минь дэвшүүлж өгөөрэй. Энэ манай биеийн тамирын салбарт бол бид нар ингээд эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг хүн арддаа бий болгоё гээд ингээд том зорилт тавьж байгаа боловч яг одоогоор бол энэ 24 оны олимп тулчихсан байгаа учраас зөвхөн олимпод бэлтгэх чиглэлийн хөрөнгө санхүүтэй холбоотой юман дээр л тодорхой арга хэмжээ авч байна. Яг нийтийн биеийн тамир руу чиглэсэн энэ үйл ажиллагаанд бол бас дутмаг байгаа шүү гэдгийг та бүхэндээ ний нуугүй хэлсэн нь дээр байх гэж бодож байгаа.

Өөрийн чинь хэлж байгаа энэ том хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бол бид нар Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай хамтарч ажиллаж байгаа. Энх-Амгалан сайдтай бид нар бүр тусгайлсан хөтөлбөр боловсруулаад ингэж ажиллаж байна. Тухайлах юм бол “Би хүмүүнлэг, эрүүл чийрэг, бүтээлч монгол хүүхэд” энэ хөтөлбөрийг улс орон даяар сургуулийн өмнөх боловсролоос нь эхлээд суулгая, хичээллүүлье гэдэг ийм зорилго явж байгаа. Таны хэлж байгаатай санал нэг байгаа. Бид та бид нар хамтдаа энэ Их Хурлын даргын санаачилсан тэр Япон лугаа хөгжсье энэ хөтөлбөрийн хүрээнд бид нар онлайн хурал хийсэн шүү дээ. Тэгэхэд Цүкүбагийн Их сургуулийн профессор Фүжита гуай хэлсэн байгаа. Дайны дараах Японы боловсролын тогтолцоонд ерөөсөө бид нар юуг голч авч үзсэн гэхээр зэрэг хөдөлмөр, технологийн хичээл, биеийн тамир, урлагийн хичээлийг л энэ 3-ыг суурь болгож авсан гэж.

Тийм учраас бол хамгийн тэргүүлэх энэ хичээлийн чиглэлд бол биеийн тамир спорт багтаж орж энэ чиглэлээр нэлээн ажлуудыг хийнэ. Улсын хэмжээгээр манай биеийн тамирын салбар чинь жилдээ 3000 гаруй тэмцээн, уралдаан ийм арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг. Ёстой 8 нас наснаас 80 насыг хүртэлх энэ орон зайнд зохион

байгуулаад тэнд бол нийтдээ нийт хүн амын бараг тал хувь нь буюу 1 сая гаруй хүн оролц.../минут дуусав./

Г.Мөнхцэцэг: Баярлалаа. Дамдинням гишүүн асуултаа асууя.

Г.Дамдинням: Нийтийн биеийн тамир олимпизмын сайдын ажлын үйл явцтай танилцаж байна. Тэгээд бас тодорхой үр дүнгүүд гаргаж байгаа юм байна. Би асуулт асуухгүй Бат-Эрдэнэ сайдаа зүгээр 2 л юман дээр та энэ хууль боловсруулахдаа анхаараадхаарай. Би яагаад энэний араас ингээд хөөцөлдөөд яваад байдаг вэ гэхээр нэгдүгээрт спорт нөгөө талд нь бас Соёлын тухай хууль гээд хууль дээр нэлээн л эрчтэй ажиллацгаасан. Бид нар боловсрол гээд яриад яваад байдаг. Тэгээд нийгэмд бол хамгийн их яригдаж байгаа 1 том асуудал юу вэ гэхээр Монгол хүүхдүүдэд хүмүүжил гэдэг юм байхгүй болчихжээ гэж. Үнэн. Тэгээд аргаа бараад бид нар Хүмүүнлэг боловсролын тухай хууль гээд л гаргах гээд ингээд боловсролын багц хуулийн хүрээнд яриад явж байгаа юм. Тэгэхээр хүмүүжилтэй холбоотой энэ боловсролыг гэр бүл, нөгөө талдаа нийгмийн зүгээс бол спорт, соёл урлагаар өгч байгаа. Би бол энэнд итгэдэг.

Тийм учраас энэ 2 салбарыг бол араас нь хөөцөлдөж ингээд явдаг юм. Тэгэхээр Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулахдаа тэд нар ёс зүйтэй холбоотой юмыг бүүр зөвхөн тамирчдад биш, спортод оролцож байгаа бүх оролцогч талуудад нь хамааруулж оруулмаар байна. Өнөөдөр л гэхэд Чөлөөт бөхийн холбооныхон маань бүжигнаад л явж байна. Монголд ер нь хуваагдаагүй холбоо алга. Хуваагдаад ирэхээрээ л амжилт нь унана. Сагсан бөмбөгийн холбоог бидний хэсэг нөхөд бүгдээрээ л та бүгд бүгдээрээ л оролцоод л ингээд л зүтгүүлсээр байгаад л энэ томоохон амжилтуудад гаргацгааж байгаа. Энэ нь үнэндээ өөрсдөдөө гэхээсээ илүүтэй бас болдог юм, бүтдэг

юм гэдэг юм харуулах гээд л хичээгээд л зүтгэж байгаа л ийм л үр дүн.

Тэгэхээр энэ хүмүүсийг чинь энэ Монголын олон мянган хүүхдүүд харж, үлгэр дуурайл аваасай, зорьсон зорилготой байгаасай, дэг журамтай байгаасай, ах эгчээ хүндэлдэг байгаасай, эх орондоо хайртай байгаасай гэдэг ийм л үлгэрийг үзүүлээсэй гэж бид нар спортыг дэмждэг. Тэгэхээр энийгээ үзүүлж чадахгүй байгаа багш нар, ивээн тэтгэгчид, тамирчид, бусад арын албаныханд хариуцлага тооцдог энэ системийг заавал тодорхой болгоно шүү Бат-Эрдэнэ сайдаа нэг.

Хоёрт нь бас ийм юм байгаа юм. Би түрүүн соёлын салбарыг зориуд дурдаад байгаа асуудал нь юу вэ гэхээр спортыг дэмжих бас нэг аргачлал нь Соёлын хуульд орсон тэр аргачлал байгаад байгаа юм Бат-Эрдэнэ сайдаа. Юу вэ гэхээр соёлын контентууд, соёлын агуулгуудад хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагч татварын хөнгөлөлт эдэлдэг ийм зохицуулалтыг Соёлын тухай хуулиар хийж өгсөн юм. Тэгэхээр та Биеийн тамир, спортын тухай хуулийнхаа шинэчилсэн найруулга уу эсвэл нэмэлт, өөрчлөлт орж ирэхдээ энэ соёлын хуульд энэ агуулгыг спортыг дэмжсэн байгууллага, хувь хүнийг татварын хөнгөлөлтөд оруулдаг энэ зохицуулалтыг оруулж ирэх талаас нь та судалж оруулаад ирээч. Тэгэхээр спорт гэдэг чинь, соёл гэдэг чинь өөрөө тэр чигтээ хөрөнгө оруулалтаар л босож ирдэг салбар. Энэ нь яагаад чухал вэ гэвэл Монгол орны ирээдүйн хүүхдүүд, одоо байгаа энэ хүүхдүүд бүгдээрээ соёлтой, хүмүүжилтэй, ёс зүйтэй иргэдийг бэлтгэхэд л зорьж байгаа юм. Боловсролтой холбоотой асуудлыг нь боловсролын салбар өгөөд л явна тийм. Энэ 2 юмыг анхаараарай л гэж танаас өсөх байна. Баярлалаа.

Г.Мөнхцэцэг: Үг хэлчихлээ тийм ээ. Миний зүгээс бас 2, 3 асуултад хариулт авъя гэж ингэж тавьж байна.

Тэгээд ер нь бол манай салбарын спортын салбарын энэ барилга байгууламжууд бас газрын маргаантай олон байгууламжууд бас байна. Спортын төв ордноос авхуулаад Улсын шигшээ багийн бэлтгэлийн баазаас авхуулаад ер нь ингээд газрын маргаантай ийм барилга байгууламжууд олон байсан. Бид нар ажлын хэсэг, Байнгын хороогоос очиж ажилласан.

Ер нь энэ газрын маргаантай асуудлууд хэдэн хувьд шийдэгдээд байгаа вэ? Спортын төв ордны барилгын газрын маргаан ямар байдлаар шийдэгдэхээр ингээд ямар түвшинд явж байна? Шигшээ багийн хувьд бэлтгэлийн төвийн газрын маргаан бол бас эцэслэгдсэн гэж сонссон. Энэ ямар байдалтай байгаа вэ? Энэ салбарын газрын маргаантай асуудлууд дээр хариулт авчих ъягээж ингэж асуулт тавьж байна.

2023 онд 2 дүүрэг, 15 сумын спорт цогцолборын заалыг ашиглалтад оруулна гээ ингээд та бүхэн маань оруулаад ирсэн байгаа. Энэ хаана хаана бас баригдаж байгаа барилга байгууламжууд байгаад байгаа вэ? Өнөөдөр 2023 оны 6 сар гээд ингээд явж байна. Эд дундаас сая бас хэдийдээ ингээд явж байдаг. Энэ юмнууд маань одоо ашиглалтад орсон яг гүйцэтгэлээрээ хийгдчихсэн байгаа газрууд нь бас хаана байна? Тийм, бас яг ийм гүйцэтгэлээр хийгдчихсэн байгаа тийм яг болчихсон байгаа гэх зүйлүүд бас харагдахгүй л байгаад байгаа. Энийг та бүхэн ямар хариулт өгөх вэ гээд.

Буянт-Ухаа спорт цогцолборыг 8 сард багтааж ашиглалтад оруулахаар бэлтгэл ажил нь хангагдаад явж байгаа гээд ингээд ярьж байна. Энэ хэдэн хувьтай явж байна вэ? Тийм, энэ дээр хариулт өгчхөөрэй. Хөгжлийн бэрхиээлтэй иргэдэд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор төслийг хэрэгжүүлэхэд гадаадын хамтрагч байгууллагатай гэрээ хэлэлцээр байгуулах ажлыг хийгдэж байгаа гэж байна. Энэ

ямар ажил, хаана хийгдэж байгаа вэ? Энэ бүтээн байгуулалттай холбоотой асуултуудыг тавья.

Дээр нь бас 2023 оны хөрөнгө оруулалтаар нийт санхүүжүүлэх дүн нь 48.8 тэрбум төгрөг байна гээд ингээд оруулж ирсэн байна. Өнөөдрийн байдлаар гүйцэтгэлд нь 11.6 тэрбум төгрөг байгаа юм байна. Энэ яагаад хаанаа ингээд гацаж, дутсан зүйлүүд байгаад бий болчхов? Энэ 4, 5 зүйлийн асуултыг тавьж байна. Энэ дээр хариулт авчихъя.

Асуултад Бат-Эрдэнэ сайдын микрофоныг бас Бат-Эрдэнэ сайд хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Тэр Буянт-Ухаа цогцолборын их засвар маш сайхан засвар хийсэн. Ажил бол үндсэндээ дууссан байгаа. Одоо бид нар улсын комисс ашиглалтад хүлээж авах энэ бэлтгэл ажлыг хангуулахаар байна. Тэгээд харамсалтай нь бол би дахиад хэлье. Биеийн тамир, спортын салбар бол ингээд бөмбөг ийш тийш нь өшиглөж байгаа юм шиг нэг парламентын бүрэн эрхийн хугацаанд эрүүл мэндийн салбарт, дараа нь Боловсрол, шинжлэх ухаан, соёл, спортын яам гээд ийшийгээ. Бүүр аялал жуулчлал Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүртэл явж байсан шүү дээ. Тэгээд энэ үе юунд явахад бол энэ хөрөнгө оруулалттай холбоотой бодлогын бүх юм нь орхигдож ирсэн ийм зүйл байна лээ.

20 оноос бол Засгийн газрын бүтцэд өөрчлөлт оруулаад Засгийн газрын Хэрэг эрхлэхийн мэдэлд буюу иүүд Ерөнхий сайдын мэдэлд очиж ажиллаж байгаад ингээд Ерөнхий сайдын эрхэлж хариуцаж байсан энэ салбаруудыг тусгайлсан эрхэлсэн сайдтай болгож ажиллуулж байгаа хүрээндээ намайг томилоод ингээд ажиллаж байгаа.

Энэ Буянт-Ухаагийн ордонтой холбоотой асуудал ийм байна. Өмнө нь бид нар чинь анх энэ ордныг барьж байгуулах гээд ашиглалтад оруулах гээд хөөцөлдөж байгаад ингээд ашиглалтад оруулахад тухайн үед ажил хариуцаж байсан улсууд нь улсын комисст хүлээж аваагүй 10 гаран жил ашиглачихсан ийм зүйл байлаа. Одоо бид нар тэр яг зургийг нь, тухайн бичиг баримтуудыг нь олж авах гээд ингээд Хятадын талд асуудал тавиад ингээд явж байгаа. Тэгээд бид нар ямар ч байсан энэ 8 сард хүлээгээд авчих байх. Тэр засвар юутай холбоотой асуудал бол ямар ч саадгүй явж байгаа. Гадна талд манай талаас хүлээсэн ийм үүргийн юмнууд байгаа.

Тэр сум орон нутагт хийгдэж байгаа спортын заал танхимуудтай холбоотой юм би түрүүн тодорхой хэлсэн. Энийг бол ямар нэгэн байдлаар биеийн тамир спортын салбарт Эрүүл мэндийн яаманд байхад ч тэр, Боловсролын яаманд байхад ч тэр энэ салбарт тусгайлсан техник хэрэгслийн юм уу заал танхимын ийм хөрөнгө гаргуулж, оруулж байсан тийм зүйл огт байхгүй ээ. Энэ хөрөнгө оруулалтыг хэн хийж байсан юм гэхээр зэрэг тойргоос сонгогдсон Их Хурлын гишүүд маань л хөөрхий өөрсдөө санаачилга гаргаж байсан.

Одоо энэ хэрэг хэрэгжиж байгаа энэ сумуудад, аймгуудад хийж байгаа энэ спортын барилга байгууламжууд нь дандаа энэ Их Хурлын гишүүдийн санаачилгаар хийж байгаа. Тэрнээс биш бол улсын төсвөөс биеийн тамирын салбарт ийм ийм сумуудад ийм ийм спортын заал танхим барьж байгуулъя гэж оруулсан хөрөнгө санхүүгийн юм огт байхгүй. Харин энэ хариуцах эзэнгүй явсан олон яамдын дунд хаягдаж байх үедээ тэр бид нарын 2004-өөс 8 онд, 8-аас 12 онд гаргасан тэр том том шийдвэрүүд өнөөдөр жишээлэх юм бол энэ нийслэлийн 9 дүүрэгт хэрэгжих ёстой тэр усан бассейнтай спортын

цогцолборуудаас Чингэлтэй дүүргийнх ашиглалтад орсон, Баянгол дүүргийн ашиглалтад орсон, Сонгинохайрхан дүүрэг ашиглалтад орсон. Бусад нь ашиглалтад ороогүй байгаа.

Аймгуудынх бол ямар ч байсан хэлтэй амтай нэг орсон байна. Тэгээд энэ чинь 10 гаран жил үргэлжилж байгаа ийм зүйлүүд байгаа. Таны асууж байгаа энэ 48.8 тэрбум төгрөгөөс гүйцэтгэл нь 11.6 тэрбум гүйцэтгэлтэй явж байгаа. Энэ ямар учиртай вэ гэж асууж байгааг манай ажлын хэсгийнхэн нэмж хариулаарай. Энэ дотор бас мөн миний энэ өгч байгаа энэ тайлбараар асуудал байгаа гэдгийг би бас тодруулж хэлье. Манайхаас хэн хэлэх юм.

Г.Мөнхцэцэг: Тэр нөгөө спортын салбарынхны ордон, мөн дээр нь хөрөнгө оруулалттай холбоотойгоор газрын маргаантай байгаа асуудлууд дээр ер нь ямаршуу түвшинд явж байгаа тэн дээр 1 номерын микрофоныг өгчихье тийм ээ. Гэрэл дарга хариулъя.

О.Гэрэл: Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Гэрэл байна. Газрын маргаантай холбоотой асуудлаар Байнгын хорооны даргын ажилласан Улсыг батлан хамгаалах, туслах нийгэмлэгийн эзэмшилд байдаг газартай холбоотой маргааны асуудал бол шүүх дээр яваа. Анхан шатын шүүх дээр яваа. 2 удаагийн шүүх хуралдаан хойшилчихсон байгаа. Хариуцагч талаас бол шүүх хурлыг хойшлуулах, хэргийн материалтай танилцах гэдэг үндэслэлээр бол 2 удаа шүүхийн ажиллагааг хойшлуулсан. Хан-Уул дүүргийн шүүх дээр бол шүүхийн ажиллагаа эхэлчихсэн явж байгаа.

Спортын төв ордны ар талынх спортын хуучнаар сургалтын төвтэй холбоотой, объекттой холбоотой асуудал бол Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар дээрээ хэргийн материалыг бүрдүүлэх чиглэлээр ажил

явж байгаа. Архиваас их олон жилийн өмнөх материалуудыг 70, 80-аад оны материалуудыг энэ тэр шүүж үзэхтэй холбоотойгоор Сангийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтарч энэ материалуудаа цуглуулах ажлууд нь явж байгаа. Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг дээрээ төрийн байгууллагуудын оролцоотой ажлын хэсэг байгуулагдаад ингээд ажлаа хийгээд явж байгаа.

Г.Мөнхцэцэг: Ер нь асуултуудад голчлоод сайд хариулчих шиг боллоо тийм. Өнөөдрийн Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны Биеийн тамир, спортын салбарын 2022-23 оны үйл ажиллагааны сэдвээр Монгол Улсын сайд, Олимп, биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Бат-Эрдэнэ сайд маань бас маш дэлгэрэнгүй өнөөдрийн бас холбоотой асуудлуудаар дэлгэрэнгүй танилцуулга хийлээ. Мөн бас энэ хуралдаанд идэвхтэй оролцсон бас оролцогчид бас талархлаа илэрхийлээд өнөөдрийн хуралдаанд энэ салбарын асуудлуудаар хангалттай мэдээлэл сонссон гэж ингэж үзэж байна.

Тэгээд ер нь цаашид Монгол Улсын Засгийн газарт энэ ер нь бас Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай оруулж ирэх хэрэгтэй байна гэж ингэж энэ үндсэн чиглэлийг бас өгч хэрэгтэй байна.

Дээр нь бас 2024 онд удахгүй бас олимп болно. Олимпын бэлтгэлийг хангах шаардлагатай байгаа. Нэн шаардлагатай байгаа. Тийм учраас энэ хангалттай бас төсөвт тэгээд төсвийн төсөлд бас хангалттай энэ түвшинд хүргэх ийм төсөв суулгаж өгөх ёстой, шаардлагатай байна гэж бас ингэж үзэж байна өнөөдөр бас Байнгын хорооны зүгээс.

Тийм учраас энэ зүйлүүд дээр бас анхаарч ажиллаарай гэдэг ийм чиглэлийг өгч байна. Тэгээд өнөөдрийн Байнгын

хороонд яг хуралдаанд идэвхтэй
оролцсон та бүхэнд баярлалаа.
Өнөөдрийн байнгын хорооны хуралдаан
өндөрлөснийг мэдэгдье.

16.00 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР